



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны стратеги 2013–2016





# Гарчиг

<b>Товчилсон үгс</b>	<b>4</b>
<b>Өмнөх үг</b>	<b>5</b>
<b>Товчоон</b>	<b>6</b>
<b>1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ</b>	<b>8</b>
<b>2. Швейцарийн хөгжлийн бодлогын зорилтууд</b>	<b>12</b>
<b>3. ШХА-ийн 2007-2012 оны үйл ажиллагааны үр дүн</b>	<b>13</b>
<b>4. Үр дагавар</b>	<b>17</b>
<b>5. Тэргүүлэх чиглэл, зорилт, үр нөлөөний таамаглал</b>	<b>19</b>
<b>6. Төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэх менежмент</b>	<b>23</b>
<b>7. Удирдлагын стратеги</b>	<b>26</b>
<b>Хавсралт 1: Хамтын ажиллагааны стратеги товчоор</b>	<b>28</b>
<b>Хавсралт 2: Үр дүнгийн хүрээ</b>	<b>29</b>
<b>Хавсралт 3: Үзүүлэлтүүдийн тайлбар</b>	<b>34</b>
<b>Хавсралт 4: Хяналт шинжилгээний систем</b>	<b>39</b>

# Товчилсон үгс

АХБ	Азийн хөгжлийн банк	НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
АН	Ардчилсан нам	НЦҮ	Нэг цонхны үйлчилгээ
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг	ТАТ	“Тогтвортой амьжиргаа” төсөл
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	ТБУТ	“Тогтвортой бичил уурхай” төсөл
ГОУХАА	Германы олон улсын хамтын ажиллагааны агентлаг	ТББ	Төрийн бус байгууллага
ДЗҮ	Дэлхийн засаглалын үзүүлэлт	УАБ	Ус ашиглагчдын бүлэг
ДӨЧТ	Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан	ҮСГ	Үндэсний статистикийн газар
ДХҮ	Дунд хугацааны үнэлгээ	ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЕХ	Европын Холбоо	ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл	ХАА	Хөдөө аж ахуй
ЗДТСХ	Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр	ХАБ	Хүнсний аюулгүй байдал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага	ХХИ	Хүний хөгжлийн индекс
МАА	Мал аж ахуй	ХХӨХС	Хөгжлийн холбогдолтой өөрчлөлтүүдийн хяналтын систем
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт	ХЯ	Хөдөлмөрийн яам
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт	ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага		

# ӨМНӨХ ҮГ

1964 онд Швейцарь, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш тус улсуудын хоорондох найрамдалт харилцаа өргөжин дэвжсээр ирсэн. 2001 онд Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ), Монгол Улсын Засгийн газраас олон улсын хамтын нийгэмлэгт хандаж гаргасан уриалгын дагуу 2002 онд Швейцарь Улсаас зудын гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлснээр Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА)-ийн Монгол дахь үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй. Энэ хугацаанд ШХА-аас тус улсад дунд хугацааны хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2004 онд хамтын ажиллагааны газраа нээсэн. Ийнхүү ШХА Монгол Улсад тулгарч буй бэлчээрийн тогтвортой менежментийн сорилт бэрхшээлүүдийг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилготой хөгжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн билээ. ШХА-ийн 2007-2012 оны анхны стратеги нь байгалийн нөөцийн менежментийг боловсронгуй болгох, иргэдийн ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж байв.

Эдгээр он жилүүдэд Монгол Улс хурдацтай, гүн гүнзгий өөрчлөлтийн үеийг туулсан. Тус улс ардчилсан, олон намын тогтолцоо, чөлөөт зах зээлийн эдийн засагт амжилттай шилжсэнээрээ дэлхий нийтийн анхаарлыг татаж байв. Монгол Улс бүс нутагтаа ардчиллын үлгэр дууриал үзүүлэх "гэрэлт цамхаг" хэмээн зүй ёсоор нэрлэгдэж байна. Ийнхүү Монгол Улс ардчилах үйлсэд гайхалтай дэвшил гаргаснаас гадна уул уурхайн их үсрэлтийн үед орсноор эдийн засаг, төсвийн орлого нь урьд хожид байгаагүйгээр өсөж байна.

Монгол Улс өнөөдөр хөгжлийнхөө үйл явцын салаа зам дээр ирээд байна. Тус улс эрдэс баялгийн нөөцөөрөө магадгүй нэгхэн үеийн дотор аж үйлдвэржсэн орнуудын хэмжээнд хүрч хөгжиж болохуйц дахин давтагдашгүй таатай боломж гарч байна. Гэвч энэхүү эрчимтэй хөгжил томоохон эрсдлийг дагуулдаг. Монгол Улс улам бүр өсөн нэмэгдэж буй төсвийн орлогоо нийгэм, эдийн засгийн тогтвортой,

эрх тэгш хөгжил болгон хувиргах уу, аль эсвэл авлига хээл хахууль, ялгавартай байдал, зохисгүй удирдлагын улмаас ядуурал, нийгмийн тэгш бус, эмх замбараагүй байдалд хүрэх үү? Иймд тус улсын хувьд дунд хугацаанд тулгарч буй нэг чухал сорилт бол улс төр, эдийн засгийн байгууллага сайжруулж, байгалийн баялгаас орж ирэх орлогыг ил тод, хариуцлагатай, эрх тэгш захиран зарцуулах явдал болоод байна.

Монгол Улсын Засгийн газар ч энэхүү сорилтыг хүлээн зөвшөөрч 2011 оноос төвлөрлийг сааруулах шинэтгэлийг эхлүүлсэн. 2011 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Швейцарь Улсад айлчлах үеэрээ энэхүү шинэтгэлийг хэрэгжүүлэх үйлсэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн билээ. Швейцарь Улс ч энэхүү урилгыг талархан хүлээн авч, Монгол Улсад шинэтгэлийн энэ чухал үед нь дэмжлэг үзүүлэх, шууд ардчиллыг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулахад туршлагаа хуваалцах болсондоо баяртай байна. Эдгээр шинэтгэл нь нийгмийн эрх тэгш хөгжил, эв нэгдлийг бэхжүүлэхэд гол үүрэгтэй гэдэгт бид итгэж байна.

Швейцариаас Монгол Улсын хөгжилд оруулах хувь нэмэр нь дээр дурдсан сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд туслахын зэрэгцээ Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-д тулгуурлах юм. Хамтын ажиллагааны стратеги нь хөдөө аж ахуй (ХАА), хүнсний аюулгүй байдал, мэргэжлийн боловсрол, сургалт (МБС), төрийн шинэтгэл, орон нутгийн засаглал ба иргэний оролцоо гэсэн үндсэн чиглэлүүдэд голлон анхаарсан нь Швейцарь Улсэдгээр чиглэлээр арвин мэдлэг, туршлага хуримтлуулсантай холбоотой. Дотоод, гадаадын түнш байгууллагуудтай хамтран боловсруулсан энэхүү стратеги нь 2013-2016 онд Швейцарь Улсаас Монгол Улсад явуулах үйл ажиллагааны гол удирдан чиглүүлэгч баримт бичиг болно.



ШХА-ийн Ерөнхий захирал, Элчин сайд  
Мартин Дахиндэн

# ТОВЧООН

**Монгол Улс хөгжлийнхөө салаа зам дээр ирээд байна.** Тус улс төвлөрсөн төлөвлөгөөт социалист эдийн засгаас чөлөөт ардчилалд харьцангуй тайван замаар шилжсэний дараа уул уурхайн салбарын их үсрэлтэд тулгуурласан эдийн засгийн урьд хожид үзэгдээгүй өсөлтийн үеийг туулж байна. Монгол Улс энэхүү түүхэн давтагдашгүй боломжийг ашиглан иргэдийнхээ тогтвортой, ирээдүйн амьдралд хөрөнгө оруулж чадах эсэхээс тус улсын улс төрийн удаан хугацааны тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил цэцэглэлт, нийгмийн эрх тэгш хөгжил хамаарна. Дэлхийн түүхэнд байгалийн нөөц баялаг ихтэй олон орон ийнхүү хөгжихийн оронд “баялгийн хараал”-д автсан эмгэнэлт тохиолдлууд бий.

**ШХА Монгол дахь үйл ажиллагаагаа 2001 онд хүмүүнлэгийн тусламжаар эхэлж байсан. Түүнээс хойш байгалийн баялгийн тогтвортой ашиглалт, ХАА, хүнсний аюулгүй байдалд түлхүү анхаарсан хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн.** Монгол Улсын эдийн засаг хагас нүүдлийн мал аж ахуй (МАА)-гаас томоохон уул уурхайд түшиглэсэн эдийн засагт эрчимтэй шилжиж байгаатай холбоотой ШХА хөгжлийн хөтөлбөрүүдээ уялдуулах хэрэгцээ гарсан. Мөн Швейцарийн Холбооны Зөвлөлөөс Парламентад өргөн барьсан 2013-2016 оны олон улсын хамтын ажиллагааны бодлогын баримт бичгийн ерөнхий зорилго, түүнд дурдсан 1) ард иргэд нөөц баялаг, үйлчилгээг адил тэгш хүртэх боломжоор хангагдах, 2) Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг

дэмжих гэсэн стратегийн зорилтуудад нийцүүлэн хөтөлбөрийн зорилтуудаа өөрчлөхөд хүрч байна.

**2007-2012 онд хэрэгжүүлсэн хөгжлийн хөтөлбөрүүд сайшаагдахуйц үр дүнтэй байсан ч гарсан ахиц дэвшил чиглэл бүрт харилцан адилгүй байлаа.** Хөтөлбөрийн үндсэн зорилго нь хөгжил буурай баруун бүсийн малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлж, баталгаажуулахад хувь нэмрээ оруулах явдал байв. Хөдөөгийн иргэдийн орлого, ажил эрхлэлтийн чиглэлд шинэлэг арга барилаар ажилласны үр дүнд хэд хэдэн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт бодит үр дүнд хүрсэн. Харин байгалийн нөөцийн удирдлагын чиглэлд гарсан үр дүн харьцангуй удаашралтай байсан юм. Учир нь холбогдох салбаруудын хувьд техникийн цогц бэрхшээл их байснаас гадна Засгийн газрын бодлогын тэргүүлэх байр сууринд байдаггүй байсантай холбоотой. Засаглалын чиглэлээр хязгаарлагдмал оролцоотой байсан ч үр дүнтэй ажиллаж чадлаа.

**Монгол Улсын нийгэм, эдийн засаг эрчимтэй өөрчлөгдөж байгаатай холбогдон ШХА-ийн 2013-2016 оны стратеги нь ХАА, хүнсний аюулгүй байдал, МБС, Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэдийн оролцоо гэсэн харилцан уялдаатай гурван үндсэн чиглэлд үйл ажиллагаагаа хандуулан ажиллах болно.**

Монгол дахь туршлагаас харахад хөдөөгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэхийн тулд



экологи, эдийн засгийг хослуулсан “ногоон” чиглэлийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Мөн хамтын ажиллагааны цоо шинэ чиглэлийг мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох богино хугацааны сургалтын чанарыг сайжруулахад зориулах шаардлагатай. Ингэснээр эдийн засгийн их үсрэлтийн үеэс бий болсон таатай нөхцлүүдийг ашиглах боломжийг хөдөөгийн залуус, мэргэжилгүй иргэдэд олгох юм. Төвлөрлийг сааруулах шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх нь бүхий л салбарт хөгжлийн үр дүн бий болгоход шийдвэрлэх ач холбогдолтой. Ийм ч учраас ШХА цаашид засаглалын чиглэлд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэн ажиллах болно.

**2013-2016 оны Швейцарийн хамтын ажиллагааны стратегийн нэг гол зорилго бол Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах явдал юм.** Энэхүү зорилгод хүрэхийн тулд ХАА, хүнсний аюулгүй байдлын чиглэлд хөдөөгийн хүн амын эмзэг бүлгийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг сайжруулах бол МБС-ын чиглэлд хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг сайжруулна. Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэдийн оролцооны чиглэлд иргэдийн төлөөллийг бодитойгоор бий болгох, орон нутгийн удирдлагыг илүү үр нөлөөтэй, үр ашигтай, шударга ажилладаг болгох, иргэдийг сэтгэл ханамжтай, иргэний нийгмийг илүү хүчтэй болгохыг зорьж ажиллана. Мөн ШХА бүхий л үйл ажиллагаандаа жөндөрийн тэгш байдлыг анхаарна.

**Хөтөлбөрийн дараагийн үе шатанд үйл ажиллагаагаа үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд болон үндэсний тогтолцоотой нягт уялдуулан ажиллана.** Үүнд: 1) Монгол Улсын Засгийн газар анхааралдаа авч, санхүүжүүлэх магадлал өндөртэй салбарт үйл ажиллагаагаа чиглүүлнэ, 2) Швейцарь Улсын бүхий л хамтын ажиллагаа нь хамтын төлөвлөлт, хамтын хэрэгжүүлэлт, хамтын санхүүжилт, хамтын үнэлгээг шаардана, 3) төсөв хөрөнгийг эмзэг бүлэгт ашиг тусаа өгөхүйц тэргүүлэх чиглэл, үйлчилгээнд хандуулах ардчилсан механизмыг бэхжүүлнэ, 4) олон талт түншүүд бүхий хамтарсан төслийг нэмэгдүүлнэ, (v) ШХА-ийн төслүүдийг бие даан хэрэгжүүлэх механизм цаашид үйлчлэхгүй.

**Хөтөлбөрийн санхүүжилтын хэмжээ 2015 онд оргил үедээ хүрч жилийн 22 сая шв.франк болох бөгөөд түүнээс хойш буурч 2020 онд дуусгавар болно.** Төсвийн нийт хэмжээ дөрвөн жилийн хугацаанд 80 орчим сая шв.франк байна. Энэхүү хамтын ажиллагааны стратегийн гурван үндсэн чиглэлд нийт төсөвлөсөн хөрөнгийн 80-аас доошгүй хувийг зарцуулах юм. Энэхүү нэмэлт санхүүжилтыг олон талт хамтын ажиллагааны байгууллагуудтай хийх стратегийн, идэвхтэй түншлэлд гол төлөв зарцуулна. Нийт 3-12 сая швейцарь франкын төсөвтэй томоохон, өргөн хүрээтэй, стратегийн төсөл хэрэгжүүлэх чиг хандлага 2015 он хүртэл үргэлжилнэ.

# 1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

**Монгол Улс улс төрийн ардчиллын институциудыг байгуулах тал дээр богино хугацаанд үлэмж ахиц дэвшил гаргаад байна.** 1990 онд социалист нийгмийн үе төгсгөл болсноос хойших 20 жилийн хугацаанд тус улс чөлөөт ардчилалд чиглэсэн улс төр, эдийн засаг, нийгмийн шилжилтийн харьцангуй тайван үеийг тууллаа. Энэ хугацаанд улс төрийн тавцанд Монгол Ардын Нам (хуучнаар Монгол Ардын Хувьсгалт Нам), Ардчилсан Нам (АН) гэсэн хоёр том нам зонхилон эрх барьж ирсэн. 2008 оны УИХ-ын сонгуулийг эс тооцвол засгийн эрх тайван замаар шилжиж байна. 2012 оны зургадугаар сард болсон сонгуулиар АН ялалт байгуулж, Шударга ёс эвсэлтэй хамтран Засгийн газраа байгууллаа.

**Олон нийтийн нээлттэй мэтгэлцээнийг дэмжсэн, иргэдийн хязгаарлагдмал оролцоог зөвшөөрсөн улс төрийн орчин бүрдсэн.** Улсын Их Хурал шинэ хууль тогтоомжийн талаар идэвхтэй, нээлттэй мэтгэлцэх, сөрөг хүчин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж нь нээлттэй байна. 2010 оноос хойш Иргэний танхимд байнгийн уулзалт зохион байгуулдаг болсноор хууль тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоо оролцоо нэмэгдэх төлөвтэй байна. Мөн 2011 оны арван хоёрдугаар сард Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсноор өмнө нь хаалттай байсан мэдээллийг олж авах шинэ гарцыг иргэдэд нээсэн юм. Гэвч төр засаг хэвлэлийн эрх чөлөөг хүндэтгэх тал дээр учир дутагдалтай хэвээр байна.

**Социализмын үеэс хойш хүний хөгжилд тогтвортой өсөлт ажиглагдсаар ирсэн боловч өсөлтийн хурдыг Зүүн Азийн орнуудынхтай харьцуулбал удаан байна.** 2011 оны байдлаар Монгол Улсад хүн амын бичиг үсэг тайлагдалт 97,5 хувь, дундаж наслалт 68.5 гарч, 2011 оны Хүний хөгжлийн

индекс (ХХИ)-ээр 187 орноос 110 дугаар байрт бичигджээ. Гэвч Монгол Улсын ХХИ нь Зүүн Азийн орнуудын дунджаас доогуур байна. Түүнчлэн боловсрол эзэмших байдал, эрүүл мэндийн үзүүлэлт нь жендэрийн хувьд харилцан адилгүй байна. Эмэгтэйчүүд дээд боловсрол эзэмших нь эрэгтэйчүүдээс илүү байгаагийн зэрэгцээ тэднээс дунджаар долоон жилээр урт насалж байна. Хөдөлмөрийн зах зээлд дэвшилт гарч, өсөлтийн төвүүд рүү шилжих шилжилт нэмэгдэж байгаа хэдий ч удирдах албан тушаал, цалин хөлс, улс төрийн оролцооны хувьд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс доогуур үзүүлэлттэй хэвээр байна. Улсын Их Хурлын 76 суудлын зөвхөн ес, Засгийн газрын сайдын 19 суудлын зөвхөн гурвыг эмэгтэйчүүд эзэлж байна.

**Монгол Улс эрдэс баялгийн нөөцөө их хэмжээгээр олборлож эхэлсэнтэй холбоотой эдийн засгийн өсөлт зогсолтгүй хурдасч байна.** Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, ХАА-н салбарын үйлдвэрлэл дээд цэгтээ хүрсний үр дүнд 2011 онд эдийн засгийн өсөлт 17,3 хувьд хүрч дээд амжилт тогтоолоо. 2016 он гэхэд уул уурхайн салбарын үйлдвэрлэл дотоодын нийт бүтээгдэхүүний 40-50 хувийг бүрдүүлэх тооцоотой байна. Одоо ч гэсэн эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспорт ноолуур зэрэг уламжлалт бүтээгдэхүүнийхээс даруй 10 гаруй дахин их байгаа бөгөөд цаашид ч энэ хандлага үргэлжлэх төлөвтэй. Харин инфляцийн түвшин хоёр оронтой тоогоор хэмжигдэж байгаа нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд заналхийлж байна. Сүүлийн дөрвөн жил дарааллан хүнсний үйлдвэрлэл нэмэгдсэн хэдий ч өргөн хэрэглээний барааны үнэ өссөн нь ядуу иргэд, ялангуяа мэргэжилгүй ажилчид, ажилгүй залуус, малчин өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа юм.



**Эдийн засгийн их тэсрэлтийг эс тооцвол хөдөө орон нутагт ядуурлын түвшин өндөр хэвээр байна. Түүнчлэн орлогын тэгш бус байдал тухайн орон нутагт төдийгүй бүс нутаг дамнан хүрээгээ тэлсээр байна.** 2012

онд Засгийн газар болон Дэлхийн Банкнаас гаргасан тоо баримтаар нийт хүн амын 30 орчим хувь нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой байгаа бол хөдөөд энэ үзүүлэлт 33 хувьд хүрчээ. Хүн амын дунд орлогын тэгш бус байдал нэмэгдэхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлт газар зүйн бүсээр харилцан адилгүй байна. Өмнөговь аймаг, нийслэл Улаанбаатар хотод уул уурхайн төвүүд шинээр бий болсноор эдийн засгийн таатай боломжууд бий болж байхад зах хязгаар бүс нутгууд хөгжлөөс хоцорч, улсын төсвийн татаасаас улам бүр хамааралтай болж байна. Үүнээс улбаалан хөдөөгөөс Улаанбаатар хот төдийгүй өмнөд бүсийн уул уурхайн аймгуудыг зорих шилжилт хөдөлгөөн эрчимжих төлөвтэй байна.


**Уул уурхайн салбараас улсын төсөвт орох орлого урьд хожид байгаагүй нэмэгдсэн нь улсын салбарын засаглалд хэт ачаалал үүсгэж байна.** Урьд нь төсвийн орлогын өсөлтийн нилээдгүй хэсгийг хавтгайрсан нийгмийн халамж хэлбэрээр зарцуулдаг байсан. Тухайлбал ард иргэдэд хишиг хүртээх, төрийн байгууллагуудын ажилчдын цалинг нэмэгдүүлэх болон популист амлалтыг биелүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд зарцуулж иржээ. Ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, инфляци өсөхийн хэрээр улсын төсвийн ачаалал нэмэгдсэн хэвээр байх төлөвтэй. Төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулж байна гэх ойлголт иргэд, олон нийтийн дунд нэмэгджээ. Монгол Улсын

талаар хийсэн судалгааны үр дүн, олон улсын индексүүдийн аль аль нь авлига хээл хахууль газар авсан нь хөгжилд томоохон саад тотгор учруулж байгааг баталсаар байна.

**Монгол Улсын эдийн засгийн байдал гадны өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд эмзэг өртөмтгий хэвээр байна. Энэ нь бүс нутгийн экспортын зах зээл, импортын эх үүсвэр, ялангуяа эрчим хүчний импортын хувьд бусдаас хараат байдгаас улбаатай.** Монгол Улсын худалдааны хамгийн чухал түнш бол Хятад. Экспортын барааны тавны дөрвөөс дээш хувийг тус улсаас авдаг бол гадагшаа импортолдог бараа бүтээгдэхүүний тэн хагасыг мөн Хятад улс руу гаргадаг байна. Монгол Улс нефтийн бүтээгдэхүүнээ бараг бүхэлд нь, цахилгаан эрчим хүчнийхээ багагүй хэсгийг Оросоос импортоор авдаг. Үүний улмаас Хятадын эдийн засгийн өсөлт сулрах, хилийн худалдаанд үлэмж саад учрах, эрдэс бүтээгдэхүүний дэлхийн нийтийн эрэлт хэрэгцээ буурах зэрэг хүчин зүйлс хямралын мөчлөг үүсгэж болохыг Монгол Улс хамгийн сүүлд 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын үеэр мэдэрсэн билээ.

**МАН-н салбарын тэнцвэргүй байдал Монгол орны байгаль орчныг доройтолдог оруулж байна.** Малын тоо толгой хэт нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрсний улмаас бэлчээр талхлагдаж, цөлжилт эрчимжин, улмаар хөдөөгийн малчин өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр алдагдаж байна. Түүнчлэн МАН-н салбарт малын халдварт өвчин, зах зээлийн боломж хомс зэрэг асуудал нүүрлэж байна.





Иймээс ч тус салбарын бүтээмж бага байна. Мөн МАА-н салбар цаг агаарын нөхцөл байдал, ялангуяа ган, зудаас ихээхэн хамааралтай хэвээр. 2009-2010 оны хооронд зуданд 10 сая мал хорогдсон нь нийт мал сүргийн 20 орчим хувь байлаа. Үүний улмаас эдийн засгийн өсөлт удааширсан нь нийт хүн амын гуравны нэгийн ажил эрхлэлт, амьжиргааны үндсэн эх үүсвэр болсон МАА-н салбар чухал хэвээр байгааг харуулсан юм. Тус салбарыг эрүүлжүүлэх, байгаль орчны тэнцвэрийг хадгалах нь хүнсний аюулгүй байдалд ч чухал ач холбогдолтой.

**Уур амьсгалын өөрчлөлт Монгол орны хувьд харилцан адилгүй нөлөөлж байна.** Сүүлийн 70 жилд цаг агаарын дундаж температур 2.1 хэмээр нэмэгдсэн нь гол төлөв хүний хүчин зүйлийн нөлөөнөөс улбаатай ургамлан бүрхэвчийн хэмжээ багассантай зарим талаар холбож тайлбарладаг. Нэг талаас цаг агаар дулаарснаар ургамал ургах хугацааг уртсах сайн талтай мэт санагдана. Нөгөө талаас энэ байдал Монгол орны баруун хэсгийн мөсөн голууд хурдацтай хайлж урсахад хүргэж байна. Иймд уур амьсгалын өөрчлөлт Монгол оронд эерэг болон сөргөөр нөлөөлж байна. Харин сүүлийн жилүүдэд үүсч байгаа байгаль орчны доройтол нь гол төлөв бэлчээр талхлалт, уул уурхайн үйл ажиллагаа, хот суурин газрын агаарын болон усны бохирдол зэрэг хүний зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй.

**Хүн ам зүйн бүтцийн хувьд Монгол Улс нэн таатай цаг үед байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээл дээрх ур чадварын хомсдлоос үүдэн энэ боломжоо бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна.** Хөдөлмөрийн насны хүн амын өсөлт ирэх арван жилд үргэлжлэх төлөвтэй ч залуусын албан бус ажилгүйдлийн хэмжээ өндөр буюу 40 орчим хувьд хүрсэн нь анхаарал хандуулах шаардлагатайг илтгэсээр байна. Шилжилтийн он жилүүдэд Монгол Улсын мэргэжлийн боловсролын тогтолцооны чанар муудсаны улмаас хувийн хэвшилд хамгийн

их эрэлт хэрэгцээтэй ажилчдыг нийлүүлэхэд хүндрэл тулгарлаа. Хөдөлмөрийн зах зээл дээрх ур чадварын хомсдлоос шууд улбаатай хоёр үр дагавар бий. Нэгдүгээрт, Монгол Улс өсөн нэмэгдэж буй эдийн засгийн эрэлт хэрэгцээгээ хангахын тулд мэргэжилтэй ажиллах хүчинг олноор импортлох шаардлагатай болж энэ нь хүн амын доторх үндсэрхэг үзлийг дэвэргэж болзошгүй. Хоёрдугаарт, томоохон хувийн компаниуд шаардлагатай ажилчдаа өөрсдөө сургаж харин жижиг аж ахуйн нэгжүүд санхүүгийн хувьд өөрөө хариуцаж дийлэхгүй байдалд орно.

**Төр засгийн чиг үүрэг, төсвийн санхүүжилтыг хэт төвлөрүүлснээс орон нутгийн түвшинд ардчилах үйл явц удааширч байна.** 2003 оноос хойш улсын хэмжээнд орон нутгийн иргэдийн хурлын сонгуулийг тогтмол явуулах ардчилсан бүтэц бий болсон ч бодит байдал дээр биеллээ олоогүй байна. Энэ нь шийдвэр гаргах үйл явц орон нутгийн түвшинд хуваарилсан хязгаарлагдмал чиг үүрэгт захирагддагтай холбоотой. Иргэдийн сонголтыг тусгах, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих механизм ч сул байна. Улсын хэмжээгээр иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд олноор ажилладаг ч зохион байгуулалт муутай, шийдвэр гаргагчдын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих, тэднийг тэнцвэртэй ажиллах талаас нь анхаарахгүй байна. Түүнчлэн төсөв санхүүг хэт төвлөрүүлснээр орон нутгийн түвшинд адил тэгш үйлчилгээ авах боломжийг алдагдуулж, улмаар хөдөөнөөс хотыг зорьсон шилжилт хөдөлгөөн нэмэгдэх болов. Засгийн газар эдгээр бэрхшээл сорилтыг шийдвэрлэх үүднээс төвлөрлийг сааруулах шинэтгэлийг 2011 оны сүүлээр эхлүүлсэн.

**Монгол Улс хөгжлийнхөө салаа зам дээр ирээд байна.** Аливаа улс байгалийн баялгийн асар их орлогыг хэр сайн удирдахаас тухайн улсын урт хугацааны улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил цэцэглэлт, эрх

тэгш байдал, нийгмийн хөгжил хамаарна. Нэг талаас Монгол Улс иргэдийнхээ тогтвортой ирээдүйд хөрөнгө оруулах түүхэн давтагдашгүй цаг үетэй тулгараад байна. Нөгөө талаас нөөц баялаг ихтэй олон орон "баялгийн хараал"-д автах, эдийн засгийн өсөлт тогтворгүйжэх, авлига хээл хахуульд идэгдэх, хөгжил удаашрах зэрэг аюулд орсон түүхтэй. Энэ нь валютын ханшны бодит хувь чангарснаас эдийн засгийн бусад салбарын өрсөлдөх чадвар буурдаг ("Голланд өвчин")-тай холбоотой. Түүнчлэн бараа бүтээгдэхүүний түүхий эдийн экспорт дэлхийн зах зээлээс ихээхэн хамааралтай болсноор улсын төсвийн орлогын хэмжээ тогтворгүйжих, баялгийг зохисгүй хуваарилсантай холбоотой.

**Монгол Улсын Засгийн газар улс орныхоо хөгжлийн үйл явцыг чадварлагаар удирдан манлайлж, олон улсын хөгжлийн агентлагуудын хүчирхэг түнш болоод байна.** Засгийн газар 2007-2021 онд хэрэгжүүлэх Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-д тулгуурласан ҮХЦБ-оороо дамжуулан дараах өргөн хүрээтэй зорилтууд тавьж, улс орныхоо хөгжлийг идэвхтэй удирдан чиглүүлж байна. Үүнд хүний чадавхийг хөгжүүлэх замаар МХЗ-уудыг хангах, өндөр технологи бүхий мэдлэгт суурилсан эдийн засаг, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох, нийт иргэдийн эрх ашигт нийцсэн ардчилсан засаглалын тогтолцоог

хөгжүүлэх зэрэг зорилт тавигдаж байна. Монгол Улсын Засгийн газар үндэсний шинэтгэлийн зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд ХАА-н хөгжил, мэргэжлийн боловсрол, захиргааны шинэтгэл зэрэг тодорхой чиглэлээр техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг Швейцарь Улсаас хүсээд байна.

**Монгол Улс уул уурхайн их үсрэлтээс хувь хүртэж чадахгүй хоцорч буй иргэдээ эрх тэгш, нийтийг хамарсан хөгжлийн төвд тавих, экологийн болон эдийн засгийн хувьд тогтвортой ирээдүйг бий болгох үйлсэд Швейцарь Улс дэмжлэг үзүүлнэ.** Монгол орон эрдэс баялагт тулгуурласан эдийн засагт шилжиж байгаагийн сөрөг үр дагаврыг ядуус, нүүдэлчин малчин өрхүүд, хөдөөгийн ажилгүй иргэд, хотын гэр хорооллын айл өрхүүд илүү ихээр мэдэрч байна. Тэдэнд тулгарч буй хамгийн том сорилт бол уламжлалт салбарын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, мэргэжлийн ур чадварын хомсдлыг арилгах, эдийн засгийн олон төрөлжилтийг хөхиүлэн дэмжих явдал юм. Нөөц баялгийн орлого нэмэгдсэнээр Засгийн газар эдгээр асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болно. Монгол Улс хөгжлийн эдгээр сорилтоо даван туулахад шаардагдах засаглалын болон техникийн мэдлэг туршлагаар Швейцарь Улс хангах болно.

## 2. Швейцарийн хөгжлийн бодлогын зорилтууд



**ШХА-ийн Монгол дахь хамтын ажиллагааны стратеги нь дэлхий нийтийн тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурал, эрсдлийг бууруулах үүднээс Швейцарийн Холбооны Зөвлөлөөс Парламентад өргөн барьсан 2013-2016 оны олон улсын хамтын ажиллагааны бодлогын ерөнхий зорилготой нягт уялдаатай.** Холбооны Зөвлөлийн шинэ бодлогод зааснаар “Тогтвортой тэргүүлэх чиглэлийн орнууд” хэмээх ангилалд орсон арван улсын нэг нь Монгол Улс юм. Өмнө нь Монгол Улс хязгаарлагдмал хугацаа, чиглэл бүхий “Тусгай хөтөлбөр”-ийн орнуудын ангилалд орж байсан. Ийнхүү ангилал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Швейцариас Монгол Улсын хөгжилд үзүүлэх санхүүжилтын нийт хэмжээ 2013-2016 онд 30 орчим хувиар нэмэгдэх болно. Харин 2020 он гэхэд ШХА-аас Монгол дахь хөтөлбөрөө дуусгавар болгохоор төлөвлөж байна. Иймд энэхүү хамтын ажиллагааны стратеги хэрэгжиж дууссаны дараа Монгол дахь Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагааг аажмаар хумиж дуусгах зорилготой өөр нэг хөтөлбөр хэрэгжинэ.

**ШХА бол Швейцарь, Монголын хөгжлийн хамтын ажиллагааг төлөөлөн ажиллаж буй холбооны Засгийн газрын агентлаг юм.** Тус агентлаг анх 2001 онд хүмүүнлэгийн тусламжаар үйл ажиллагаагаа эхэлж, 2004 оноос хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлсэн билээ. Уг хөтөлбөрийн үндсэн чиглэл нь байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, ХАА-н хөгжил, хүнсний аюулгүй байдлын асуудал байсан. Анх хүмүүнлэгийн тусламж үзүүлж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш Швейцарийн хөгжлийн хөтөлбөрт баримталж ирсэн нэг гол чиглэл бол уламжлалт нүүдлийн МАА-н гамшгийн эрсдлийг бууруулах явдал юм. Монгол, Швейцарь хоёр орон 1964 онд дипломат харилцаа тогтоосноос хойш найрсаг харилцаатай явж ирсэн бөгөөд өнөөдөр уг харилцаа хөгжлийн үр өгөөжтэй хамтын ажиллагаа болон хувираад байна. Мөн социализмын үеэс хойш Швейцарийн төрийн бус байгууллага (ТББ)-уудын хэд хэдэн төлөөлөгч Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байлаа.

**Олон улсын хамтын ажиллагааны шинэ бодлогод тусгагдсан Швейцарь, Монголын хамтын ажиллагааны үндсэн хоёр зорилтод өнөөгийн хурдацтай өөрчлөгдөн буй нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тусгасан байдаг. Ингэхдээ “Нөөц баялаг, төрийн үйлчилгээг адил тэгш хүртэх боломжоор хангах”, “Ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих” гэсэн зорилт тавьжээ.** Эрдэс баялгийн нөөцөд тулгуурласан эдийн засгийн их тэсрэлт Монголын улс төр, захиргааны институциудын чадавхид томоохон сорилт болж байна. Нийт иргэдийг хамарсан эрх тэгш, тогтвортой хөгжлийг бий болгоход эдгээр институци шийдвэрлэх үүрэгтэй. Швейцарь Улс энэхүү нөхцөл байдлыг харгалзан, Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр, хөгжлийн чиглэлийн бусад гол оролцогчидтой зөвшилцсөний дагуу олон улсын хамтын ажиллагааны бодлогын гурван гол тэргүүлэх чиглэлийн дагуу хөгжлийн асуудлуудыг авч үзэх болно. Эдгээр нь 1) ХАА, хүнсний аюулгүй байдал, 2) Мэргэжлийн боловсрол, 3) Захиргааны шинэтгэл, орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоо гэсэн гурван үндсэн чиглэл юм.

# 3. ШХА-ийн 2007-2012 оны үйл ажиллагааны үр дүн

**Монголын өндөр ач холбогдолтой салбаруудад хоёр талын хамтарсан, өөрийн гэсэн өнгө төрх бүхий төслүүдийг хэрэгжүүлж ирснээрээ Швейцарь Улс Монголын гол түнш орон болсон.** Монгол дахь ШХА нь үр дүнтэй, бодитой үйл ажиллагаа явуулахаас гадна газар зүйн хувьд бүсчилж болон сэдэвчилсэн байдлаар ядуурлыг бууруулахад анхаарч ажилладгаараа талархал хүлээж, нэр хүндтэй ажиллаж ирсэн. Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд ШХА ядууралд хамгийн их нэрвэгдсэн баруун бүсийн аймгуудад үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан нь бүхий л оролцогч талуудын зүгээс өндөр үнэлгээ авсан юм. Түүнээс хойш баруун бүсийн аймгууд бусад бүс нутгийнхныг олон талаар гүйцэж хөгжиж чадсаны нэг илрэл нь эдгээр бүс нутагт ядуурлын түвшин буурсан явдал юм. Мөн МАА, төмсний үйлдвэрлэл, бичил уурхай, төрийн үйлчилгээг сайжруулах зэрэг олон чухал салбарт амьдралд ойр арга барилаар ажиллаж ирсэн тэргүүлэх хандивлагч гэдгээрээ ШХА хүндэтгэл хүлээдэг. ШХА нь төсөл хэрэгжүүлэх эрхийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад олгох, олон улсын багийн дэмжлэгтэйгээр төслийг өөрөө хариуцан хэрэгжүүлэх арга барилыг сонгон ажиллаж ирсэн.

**Швейцарийн хамтын ажиллагааны 2007-2012 оны стратегийн ерөнхий зорилго нь байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, нөхөн сэргээлтийг сайжруулах, байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн бодлогыг дэмжих замаар хөгжил буурай баруун бүсийн малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, баталгаажуулахад хувь нэмрээ оруулах явдал байлаа.** Зургаан жилийн хугацаанд 58 сая орчим шв.франкын төсөвтэй хэрэгжсэн уг стратеги гурван үндсэн чиглэлд анхаарч ажилласан. Үүнд: 1) ХАА, бичил уурхайн салбарт голлон анхаарч, хөдөөгийн ядууст ажил эрхлэх, зах зээлийн боломжуудыг бий болгох замаар орон нутгийн иргэдийн орлого, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, 2) Байгалийн нөөцийн удирдлага, ялангуяа бэлчээрийн тогтвортой ашиглалтыг сайжруулах, малчдын гамшгийн эрсдлийг бууруулах, 3) Төрийн

захиргааны үйлчилгээний хүртээмж, орон нутгийн захиргаад, иргэдийн бүлгүүдийн өөрөө удирдах чадавхийг дээшлүүлэх замаар засаглалыг сайжруулах зэрэг болно.

**2007-2012 онд хэрэгжүүлсэн хөгжлийн хөтөлбөрүүд сайшаагдахуйц үр дүнтэй байсан ч хамтын ажиллагааны үндсэн чиглэл бүрийн ахиц дэвшил харилцан адилгүй байлаа.** Хөдөөгийн иргэдийн орлого, ажил эрхлэлтийн чиглэлд харьцангуй бага санхүүжилттэй байсан ч шинэлэг арга барилаар ажилласны үр дүнд хэд хэдэн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт баттай, биет үр дүнд хүрлээ. Швейцарь Улс гол хандивлагчаар ажилласан байгалийн нөөцийн удирдлагын чиглэлд ахиц дэвшил ерөнхийдөө удаан байсан нь энэ салбарт тулгамдсан асуудлууд туйлын нарийн түвэгтэйн дээр Монгол Улсын Засгийн газраас бодлогын тэргүүлэх ач холбогдол бага өгсөнтэй холбоотой. Засаглалын чиглэлээр гол төлөв төрийн захиргааны үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд хязгаарлагдмал оролцсон ч үр дүн сайтай байлаа. Жендэрийн тэгш байдлын асуудлыг нийтлэг сэдэв болгон дэмжлэг үзүүлсний зэрэгцээ Монгол Улсын Жендэрийн тэгш байдлын үнэлгээг Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран боловсруулсан.

## 3.1 Хөдөөгийн иргэдийн орлого ба ажил эрхлэлт

Төмсний үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг болсноор хөдөөгийн хүн амын хоол тэжээлийн хангамж сайжирч, өрхийн орлого нэмэгдэн, ядуурал буурч улмаар хүнсний аюулгүй байдал дээшиллээ. ШХА-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Монгол төмс” хөтөлбөрөөс үрийн төмсийг шинэчлэх ажил амжилттай явагдлаа. Шинэ сортын төмс нэвтрүүлснээр ургацын хэмжээ тэн хагасаас илүүгээр нэмэгдэж, нийт 21,600 тариаланчийн дундаж орлого гуравны нэг орчим хувиар өссөн байна. 2004 онд Монгол Улс дотоодын төмсний зах зээлийн эрэлт хэрэгцээнийхээ 55 хувийг хангаж байсан



бол өнөөдөр энэ хэрэгцээгээ дотооддоо бүрэн хангах чадвартай боллоо. Цаашлаад нэмүү өртөг бий болгох, тэр ч байтугай илүүдэл бүтээгдэхүүнээ хөрш орнуудад экспортлох хэмжээнд хүрээд байна.

**Бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны мэргэжил болгож, хуулиар хүлээн зөвшөөрүүлсэн нь "нинжа" хэмээх хувиараа ашигт малтмал олборлогчдын амьжиргааг дээшлүүлэх, ажлын байрыг баталгаажуулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.** ШХА "Тогтвортой бичил уурхай" төсөл (ТБУТ)-өөрөө дамжуулан байр сууриа идэвхтэй илэрхийлсний үр дүнд Монголд хууль бусаар ашигт малтмал олборлож байсан 100 гаруй мянган бичил уурхайчдыг албан ёсны эдийн засгийн салбарт оруулж тооцох сэтгэлгээний өөрчлөлт авчирлаа. Ийнхүү бичил уурхайчдыг хуулиар хүлээн зөвшөөрснөөр тэд олборлосон бүтээгдэхүүнээ албан ёсны зах зээлийн үнээр борлуулах боломжтой болсон. Түүнчлэн шинээр гарсан хуулийн зохицуулалтаар орон нутгийн бичил уурхайн нөхөрлөлүүдэд олборлолтын газар олгох эрхийг сумын захиргаадад олгосны үр шимийг 3,000 гаруй бичил уурхайчин хүртэж байна.

**Төрийн үйлчилгээг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхэд үзүүлсэн дэмжлэг орон нутгийн эдийн засгийн хөгжилд түлхэц боллоо.** Гурван жилийн өмнөөс хэрэгжиж эхэлсэн Швейцарийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд 12 аймгийн нийт 531 аж ахуй нэгж төрийн үйлчилгээ гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтаас шалгарч, нийт зургаан сая шв.франкын өртөгтэй 687 гэрээ байгуулагдсан. Өмнө нь ийм төрлийн шалгаруулалтад ихэвчлэн Улаанбаатар хотын компаниуд сонгогдон, гэрээ байгуулдаг байжээ. Түүнчлэн тендер шалгаруулалтын ажиллагаанд орон нутгийн ТББ-ууд оролцох болсон нь хяналтыг улам сайжруулж өгсөн.

**ШХА-ийн "Ногоон алт" төсөл нь бэлчээр нутгийг хадгалж хамгаалах, малчдын бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тэднийг бэлчээр ашиглагчдын бүлгийн зохион байгуулалтад амжилттай оруулж байна.** 2007-2012 онд МАА-н үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, маркетингийг сайжруулах арга хэмжээ авсны үр дүнд төсөлд хамрагдсан малчдын орлого 30 хувиар нэмэгджээ. 2012 оны байдлаар "Ногоон алт" төслийн бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-үүдээс 20 хоршоо төрөн гарч бизнесийн үйл ажиллагаа явуулснаар жилд нийтдээ 400,000 шв.франкын нэмэлт орлого олж

байна. Түүнчлэн ШХА-ийн санхүүжилттэйгээр Мерси Кор байгууллагын хэрэгжүүлж буй төсөл 3,000 хөдөөгийн үйлдвэрлэгчдийн бүлэгт дэмжлэг үзүүлснээс сүүлийн гурван жилд 564 ажлын байр шинээр бий болж, 1.6 сая шв.франкын нэмэлт орлого бүрдүүлжээ.

**Малын халдварт өвчин, түүний дотор хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг малын бруцеллөз өвчин, махны экспортод гол саад учруулдаг шүлхий өвчнийг хяналтад авах үндэс суурийг тавилаа.** Монгол Улс хүний бруцеллөзын халдварын үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлдэг. ШХА Монголын Засгийн газартай хамтран бруцеллөзын хяналтын туршилтын төсөл хэрэгжүүлсний үр дүнд мал сүргийг вакцинжуулах аргыг сайжрууллаа. Мөн шүлхий өвчнийг илрүүлэх, хянах арга хэмжээг эрчимжүүлснээр Монгол Улсын баруун бүсийг шүлхийгүй бүсээр албан ёсоор зарлах тухай хүсэлт гаргах боломж бүрдлээ. Засгийн газраас малын халдварт өвчний хяналтыг бэхжүүлэх чиглэлээр Швейцарь Улстай хоёр талын хамтын ажиллагааны шинэ төсөл хэрэгжүүлэхээр болов.

**Гол сургамж: Дан ганц амьжиргааны уламжлалт хэв маягийг дэмжих нь эдийн засгийн эрчимтэй шилжилтийн үед хөдөөгийн ядуурлыг бууруулах, эрх тэгш хөгжлийг бий болгоход хангалтгүй.** Швейцарийн хамтын ажиллагааны 2007-2012 оны стратегид нүүдэлчин малчдын уламжлалт амьжиргааны арга хэлбэрийг хадгалж хамгаалахад онцлон анхаарч байсан. Харин хөтөлбөрийн дараагийн үед ШХА-ийн зүгээс үзүүлэх дэмжлэг туслалцааг эрчимтэй өөрчлөгдөж буй орчин нөхцөлтэй уялдуулан шинэчлэх хэрэгтэй болоод байна. Цаашилбал, ШХА-ийн “Ногоон алт” төслийн туршлагаас анх байгаль орчныг хамгаалах зорилгоор байгуулсан бэлчээр ашиглагчдын хэсгүүд нэмүү өртөг бий болгох, хамтарсан борлуулалт хийх зэрэг эдийн засгийн нөөц боломж агуулж байгааг илрүүлсэн юм.

### 3.2 Байгалийн нөөцийн удирдлага

**Малчдыг БАХ-ийн зохион байгуулалтад оруулснаар бэлчээрийг илүү тогтвортой ашиглах удирдлагыг бий болгож, байгалийн гамшигтай тэмцэх бэлэн байдлыг сайжруулаа.** “Ногоон алт” төслийн туршлагад тулгуурласан төрийн шинэ зохицуулалтаар бэлчээрийн менежментийн бүрэн эрхийг орон нутгийн удирдлагад шилжүүлсэн. Үүний үр дүнд 15,000 малчин БАХ-ийн зохион байгуулалтад орж, төсөл хэрэгжүүлэх хугацаанд бэлчээр ашиглалтын 470 гаруй гэрээг орон нутгийн захиргаатай байгууллаа. Түүнчлэн БАХ-үүд 3.4 сая га талхлагдсан бэлчээрийг 1-3 жилийн

хугацаанд нөхөн сэргээхээр өнжөөжээ. Мөн хадлан авах, тэжээлийн ургамал тарих ажлыг нэмэгдүүлснээр малчдын гамшгийн эсрэг тэмцэх бэлэн байдлыг сайжруулаад байна.

**Малын индексжүүлсэн даатгалын схемийг эргэлтэд оруулснаар малчдын гамшигтай тэмцэх нөхцлийг дээшлүүллээ.** Улсын ба хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр Дэлхийн Банк санаачлан, ШХА-ын хамтын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй малын даатгалын схемд хамрагдах малчдын тоо тасралтгүй өссөөр байна. Зудын дараах жил буюу 2011 онд төсөлд хамрагдсан 15 аймгийн 10,880 малчин буюу нийт малчин өрхийн 9.3 хувь нь даатгалд хамрагджээ. Уг даатгалын схемд Швейцарийн талаас үзүүлж буй дэмжлэг нь “Ногоон алт” төслийн БАХ-ийн бүтэцд зохицсон бүлгийн даатгалын хэлбэрийг нэвтрүүлэх замаар даатгалын үнэ цэнийг нэмэгдүүлж байна. 2012 оноос уг даатгалын хамрах хүрээг өргөжүүлж улсын хэмжээнд хэрэглэх боллоо.

**Иргэдийн оролцоот усны менежментийг усжуулалтын системийн шинэчлэлтэй хослуулсан нь ус ашиглалтын зөрчлийг багасгах, цөлжилтийг сааруулах, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үр нөлөөтэй арга болох нь нотлогдлоо.** Ховд аймагт ШХА-ийн дэмжлэгтэй 1,200 ногоочинг хамарсан Ус ашиглагчдын бүлэг (УАБ)-үүд байгуулагдаж, Засгийн газар 1,600 га тариалангийн талбайг хамарсан усжуулалтын систем байгуулахад хөрөнгө орууллаа. Энэхүү хамтарсан хүчин чармайлтын үр дүнд ус ашиглалттай холбоотой зөрчил маргаан илт буурсны зэрэгцээ ус хэмнэх, хөрс ус хамгаалах, ургац нэмэгдүүлэхэд чиглэсэн тариалангийн дэвшилтэт арга технологиудыг туршин нэвтрүүлсэн байна.

**ШХА мөнгөн усгүй технологиор алтны хүдэр боловсруулах цехийг Монголд амжилттай туршин нэвтрүүлсэн нь дотооддоо төдийгүй олон улсад үлгэр дууриал болж байна.** Төв аймгийн Борнуур суманд орших мөнгөн усгүйгээр хүдэр боловсруулах үйлдвэрийг хуучин бичил уурхайчин байсан иргэд эзэмшин ажиллуулж байна. Уг загварыг бичил уурхайчид олноор төвлөрч ажилладаг өөр хоёр ч газар хуулбарлан хэрэглэлээ. Эдгээр гурван үйлдвэр нийтдээ 2,500 бичил уурхайчинд үйлчилж, жилд дунджаар 7.5 сая шв.франкын өртөгтэй боловсруулсан алт гаргаж байгаагийн үр шимийг нутгийн ард иргэд хүртэж байна. Энэ загварыг Африкийн зарим оронд ч туршин нэвтрүүлсэн байдаг.

**Гол сургамж: Орон нутагт малчид, тариаланчдын дунд байгалийн нөөцийн тогтвортой удирдлагын практик үндэс**

**суурь тавигдсан ч төвлөрсөн бодлогын хэмжээнд өөрчлөлт гарахад тодорхой хугацаа шаардлагатай.** Орон нутагт байгаль орчны чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтыг өөрийн болгож эзэмших явдал сайн байгаа нь Швейцарийн техникийн туслалцаа үр дүнтэй, бодит үр өгөөж авчирсантай холбоотой. Бодлогын түвшинд авч үзвэл өмнөх Засгийн газрууд байгаль орчны менежментийн асуудал дээр ач холбогдол бага өгч ирсэн. Үүнээс улбаалан ШХА-аас бэлчээрийн менежментийн засаглалын хүрээг сайжруулахад гаргасан хүчин чармайлтууд ихэнхдээ үр дүнгүй болж байлаа. Шинэ Засгийн газраас “ногоон” салбарт тэргүүлэх ач холбогдол өгснийг төвлөрлийг сааруулах шинэтгэлтэй хослуулвал ирээдүйд байгалийн нөөцийн удирдлагын тулгамдсан асуудлуудыг илүү үр дүнтэй шийдвэрлэх боломжтой болох юм.

### 3.3 Засаглал

**Нэг цонхны үйлчилгээ (НЦҮ)-ний төвүүдийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн нь иргэдийн хувьд төрийн захиргааны үйлчилгээ авах боломж, хүрээг нэмэгдүүллээ.** ШХА Меконгийн бүс нутагт НЦҮ-г амжилттай хэрэгжүүлсэн туршлагад тулгуурлан ийм

төвүүдийг 21 аймгийн төв, таван сум, Улаанбаатар хотын есөн дүүргийн нийт 35 газар байгууллаа. Өнөөдрийн байдлаар эдгээр НЦҮ-ний төвд давхардсан тоогоор нийт 4.3 сая хүн үйлчлүүлсний 2.8 сая нь хөдөө орон нутгийн, 1.5 сая нь Улаанбаатар хотын иргэд байна. НЦҮ-ний төвүүдэд үйлчлүүлэгчдийн 90 хувь нь цаг, мөнгөө хэмнэсэндээ байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн иргэдэд ил тод үйлчлэх байдлыг сайжруулсан нь төрийн албан хаагчдын шан харамж нэхэх зуршлыг бууруулсан хэмээн тэд үзэж байна.

**Гол сургамж: Засаглалыг сайжруулахад туслах нь бусад салбарт хөгжлийн үр дүнг нэмэгдүүллээ.** Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр (ЗДТСХ)-ийн 2010 оны Дунд хугацааны үнэлгээ (ДХҮ)-нд Монгол Улсын хөгжлийн үйл явцын онцлогыг харгалзан үзсэний үндсэн дээр засаглалын асуудлыг Швейцарийн хөгжлийн стратегийн гурав дахь үндсэн чиглэл болгон оруулахыг зөвлөмж болгосон. Одоогоор энэ чиглэлээр хуримтлуулсан туршлага хомс боловч төр засгийн улс төрийн хүсэл зориг хүчтэй, дотоодын түншүүд дэмжихэд бэлэн байгаа ийм нөхцөлд олон шат (төв, орон нутгийн), олон салбарыг хамарсан арга барил хэрэглэх нь хөгжлийн үр дүнг нэмэгдүүллээ гэж үзэж байна.



## 4. Үр дагавар

**Өнөөдөр Монгол Улсын хөгжилд тулгарч буй гол сорилт бол эрдэс баялагт суурилсан эдийн засгийн их тэсрэлтийг нийт иргэдийнхээ чинээлэг, эрх тэгш, тогтвортой ирээдүй болгон хувиргах явдал юм.** Уул уурхайд ажиллаж байгаа Монгол хүн бүрээс 20 дахин илүү хүн мал аж ахуй, бичил уурхай гэх мэт мэргэжлийн ур чадвар бага шаардах ажил эрхэлж байна. Энэхүү “үр өгөөж ихтэй капитал их шаардсан” ба “үр өгөөж багатай ажиллах хүч их шаардсан” салбарын хоорондох зөрчил хурцадмал хэвээр байх талтай. Түүнчлэн Монгол Улс хөдөө орон нутагт үүсээд байгаа ядуурал, залуусын ажилгүйдэл, авлига, жендэрийн тэгш бус байдалтай ирэх жилүүдэд тэмцэх шаардлагатай болно. Улс орны хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зориулсан улсын төсвийн санхүүжилт ч цаашид нэмэгдэх юм. Швейцарь Улс Монгол Улсын Засгийн газартай бодлогын түвшинд яриа хэлэлцээрээ эрчимжүүлж, мэргэжлийн өндөр мэдлэг чадвар, туслалцаа шаардсан онцгой чиглэлүүдээр нэмэлт дэмжлэг үзүүлэх болно.

**Хөгжлийн нөхцөл байдал эрчимтэй өөрчлөгдөж байгаатай холбогдуулан Швейцарийн хамтын ажиллагааны 2013–2016 оны стратегийн үндсэн чиглэлийг (i) экологийг эдийн засагтай уялдуулах, (ii) мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх, (iii) засаглалын шинэтгэлд үзүүлэх дэмжлэгийг гүнзгийрүүлэхэд чиглүүлнэ.** ШХА-ийн Монгол дахь туршлагаас үзэхэд байгалийн нөөцийн удирдлага, ХАА, нэмүү өртгийн сүлжээ, маркетингийн асуудлуудыг нэгтгэн “ногоон” чиглэл болгон хэрэгжүүлэхээр боллоо. Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох богино хугацааны сургалтуудын чанарыг дээшлүүлж, улмаар хөдөөгийн залуус, мэргэжилгүй иргэдийг эдийн засгийн тэсрэлтийн үйл явцад татан оролцуулахад өөр цоо шинэ чиглэл бий болгон ажиллана. Төвлөрлийг сааруулах шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх нь бүхий л салбарын хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой тул ШХА-аас засаглалын чиглэлд оруулах хөрөнгө оруулалт нэлээд нэмэгдэнэ.





**Хамтын ажиллагааны шинэ стратегийн үр шимийг уул уурхайн үсрэнгүй хөгжлийн ард хоцорсон иргэд хүртэх болно.** Хагас нүүдлийн МАА-гаас томоохон аж үйлдвэржсэн уурхайн эдийн засагт эрчимтэй шилжиж буйтай холбоотой үүсч буй шинэ боломжуудаас дараах нийгмийн бүлэг хамгийн их хоцрогдож байна. Үүнд ядуу малчид, хөдөөгийн малгүй иргэд, мэргэжилгүй ажилчид, бичил уурхайчид төдийгүй Улаанбаатар хотын гэр хороололд оршин суугаа иргэд ч зарим талаар хамрагдаж байна. Иймээс хамтын ажиллагааны шинэ стратеги нь газар зүйн хувьд хөдөө орон нутаг руу чиглэсэн хэвээр байх юм. Энэ нь шилжилт хөдөлгөөнийг бууруулах Засгийн газрын бодлоготой ч нийцэж байна. Ингэхдээ ШХА зөвхөн баруун аймгуудад чиглэж ажилладаг байснаа тэлж улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулна. Түүнчлэн Улаанбаатар хотын гэр хороололд чиглэсэн зарим үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлнэ.

**ХАА-н салбарын бүтээмжийг нэмэгдүүлснээр хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, улмаар хөдөө орон нутагт ажлын байр шинээр бий болгоно. Үүний зэрэгцээ МАА-н салбарыг байгаль орчны тэнцвэрийг хангах замаар хөгжүүлснээр малчдын тогтвортой амьжиргааг дээшлүүлэхэд чухал түлхэц болно.** ШХА ХАА-н салбарт нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, бага орлоготой иргэдийг зах зээлтэй холбоход онцгой анхаарна. Мөн малын эрүүл мэнд, хүнсний ногооны үрийн шинэчлэл гэх мэт техникийн өндөр хамааралтай салбарт үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ. Хөтөлбөрийн дараагийн үед бэлчээрийн менежментийн чиглэлд оруулах гол хувь нэмэр бол экологийн бүсчлэлийн аргаар малын тоо толгойн тогтвортой хэмжээг тогтоох, экологийн баримжаатай чадамжид тулгуурласан бэлчээрийн менежментийн системийг бий болгох явдал юм. БАХ дээр тулгуурласан аргачлал, усны менежмент, байгаль орчны

боловсролын чиглэлд гаргасан анхны нааштай үр дүнгээ бататган, цаашид улам өргөжүүлнэ.

**МБС-ыг сайжруулж, амьдралд илүү ойр болгосноор Монгол залуусын ажил эрхлэх боломжийг дээшлүүлнэ. Ирэх жилүүдэд бичил уурхай эрхлэх явдал орон нутгийн эдийн засгийн нэг чухал үйл ажиллагаа хэвээр байх болно.** Орчин үеийн чанар сайтай мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох дадлага сургалтыг дэмжих нь хөдөлмөрийн зах зээл дээрх хомсдолыг арилгах, эдийн засгийн олон төрөлжилтийг дэмжихэд ихээхэн үр өгөөж өгнө. Биеийн хөдөлмөр ихээр шаарддаг бичил уурхайн салбарт зохицуулалт хийх, зах зээлтэй холбохыг дэмжих замаар уурхайчдын амьжиргааг дээшлүүлэх боломжтой. Швейцарь Улс бичил уурхайг албан ёсны болгох бодлогыг үргэлжлүүлэн дэмжинэ. Ингэхдээ эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг сайжруулах, чөлөөт худалдааны боломжийг нээх замаар хөхиүлэн дэмжинэ.

**Иргэний нийгэм, төрийн үйлчилгээ, төсвийн хөрөнгийг тэгш хүртээмжтэй ашиглах явдал учир дутагдалтай хэвээр байгаа ч сайжруулах боломжтойг НЦҮ төсөл харуулсан.** Швейцарь Улс НЦҮ төслийн нааштай үр дүнд тулгуурлан Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлээд байгаа төвлөрлийг сааруулах өргөн хүрээтэй шинэтгэлийн хөтөлбөрт дэмжлэг үзүүлнэ. Аливаа нээлттэй, олон ургальч нийгэмд иргэдийн бүлгийг идэвхжүүлж, бүх шатны шийдвэрийн чанарыг сайжруулахад ИНБ-ууд чухал хувь нэмэр оруулдаг. Хэрэглэгчдийн бүлэг, иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, эвлэл холбоодыг бэхжүүлэх явдал бол Монгол дахь ШХА-ийн нэрийн хуудас юм. ИНБ-уудыг хөгжүүлэх чиглэлээр цаашид үзүүлэх дэмжлэг нь Дэлхийн Банк болон ШХА-ийн хамтарсан төсөлд тулгуурлана. Төслийн эхний шат ИНБ-ын төлөөлөгчдийн удирдлага, манлайллын чадавхийг хөгжүүлэхэд чиглэх юм.

# 5. Тэргүүлэх чиглэл, зорилт, үр нөлөөний таамаглал

**Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2016 оны стратегийн зорилго бол Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах явдал юм.** ШХА уг стратегийн зорилгоо (1) ХАА, хүнсний аюулгүй байдал; (2) МБС; (3) Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэдийн оролцоогэсэн гурван үндсэн чиглэлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ. ШХА-ийн үйл ажиллагааны нийтлэг сэдэв болох жендэрийн тэгш байдал нь хөгжлийн үйл явц дахь жендэртэй холбоотой асуудлуудын ач холбогдлыг онцлох замаар иргэд, эрх бүхий байгууллага, түншүүдтэй харилцах, тэдний ойлголт мэдлэгийг дээшлүүлэх арга хэрэгсэл юм. 2013-2016 оны хамтын ажиллагааны стратегид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэхүү жендэрийн шинэ зохицуулалт бүх төсөл, хөтөлбөрүүдэд тусгагдах юм.

## 5.1 ХАА, хүнсний аюулгүй байдал

**ХАА, хүнсний аюулгүй байдлын үндсэн чиглэл нь хөдөөгийн эмзэг бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх зорилготой.** Энэ зорилгыг биелүүлэхийн тулд хөдөлмөрийн бүтээмж, зах зээлийн боломж, амьжиргааны чиглэлээр: (i) малчид, тариаланчдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх; (ii) малчид, тариаланчдын зах зээлийн боломжийг дээшлүүлэх; (iii) малчид, тариаланчдын амьжиргааны аюулгүй байдлыг сайжруулах гэсэн харилцан уялдаатай гурван үр дүнд чиглэж ажиллана. Энэхүү үндсэн чиглэлийн үр дүнгийн “гурвалжин” нь байгалийн нөөцийн тогтвортой удирдлагын үйл ажиллагааг ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэх стратеги болон зах зээлийн боломжтой хослуулах хэрэгтэй гэж үзэж байна. Энэ нь Монголын ХАА-н үйлдвэрлэлд орчин үеийн үйлдвэрлэлийн орц талаас нь төдийгүй газрын тогтвортой, нийтэд хүртээмжтэй менежмент талаас нь хөрөнгө

оруулна гэсэн үг юм. Мөн ШХА-ийн төсөл хөтөлбөрүүд газрын тогтвортой менежментээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах ажлыг шууд бусаар дэмжинэ.

**Малчид, тариаланчдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд малын эрүүл мэнд, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэл, ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоог сайжруулж, үйлдвэрлэгчдийг зах зээлтэй холбоход онцлон анхаарна.** ШХА өмнөх ололт амжилтандаа тулгуурлан “Малын эрүүл мэнд” төсөл хэрэгжүүлж, малын халдварт өвчний хяналт, мал эмнэлгийн боловсролыг дээшлүүлэхэд үргэлжлүүлэн хөрөнгө оруулна. Ялангуяа махны экспортод гол саад тотгор учруулдаг бруцеллёз, шүлхий өвчний хяналтад онцгой анхаарал хандуулах юм. Төмсний үр шинэчлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн туршлагадаа тулгуурлан хүнсний ногооны үр шинэчлэх төсөл хэрэгжүүлнэ. Түүнчлэн хөтөлбөрийн дараагийн үед БАХ-үүдийг шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлдэг байгууллагуудтай холбож, тэдний эрэлтэд тулгуурласан дэмжлэг үзүүлэх, бага орлоготой малчдын зах зээлийн чадавхийг сайжруулах боломж бүхий ХАА-н дэд салбаруудад чиглэж ажиллахыг зорино.

**Хамтын ажиллагааны арга аргачлалыг байгаль орчны хамгаалал, бэлчээрийн тогтвортой менежментээс гадна нэмүү өртөг бий болгох, зах зээлийн боломжууд нээх чиглэлд ашиглана.** Тариаланч, малчдын бүлгүүд бизнесийн үйл ажиллагааг өргөтгөж, хоршоо, үйлдвэрлэлийн өргөтгөсөн бүлгийн хэлбэрээр хөгжүүлж байна. Хоршоодын хувьд зах зээлд нэвтрэх, бизнесийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардлагатай удирдлагын бүтэцтэй болох тал дээр бэрхшээл тулгарч байна. ШХА-ийн зүгээс маркетинг, нэмүү өртгийг сайжруулах замаар орлого олох боломжуудыг бий болгоход БАХ, УАБ, малчид, тариаланчдын

холбоод, хамтын үйл ажиллагааны бусад бүлэгтэй хамтарч ажиллана. Түүнчлэн ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээг БАХ-ийн тогтолцоотой холбох замаар тэдний тогтвортой байдлыг сайжруулна.

**Хөдөөгийн иргэдийн амьжиргааг илүү баталгаатай болгохын тулд тэдний мал сүргийг даатгалд хамруулах, төрөөс тэтгэмжийг оновчтой олгох, байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангахад чиглэсэн бэлчээрийг түр болон урт хугацаагаар эзэмшихийг хуульчлах хэрэгтэй.** Малын даатгалд үргэлжлүүлэн анхаарах замаар гамшгийн эрсдэл бууруулах стратегийг дэмжинэ. Түүнчлэн сумын түвшинд гамшгийн эрсдэл бууруулах ажиллагааг сайжруулах чиглэлээр Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-тэй хамтарч ажиллах боломжийг судална. Бэлчээрийн менежмент, усны нэгдсэн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх асуудал ШХА-ийн үйл ажиллагааны гол чиглэл хэвээр байна. Сумын түвшинд татаасыг тогтвортой, зөв чиглүүлж зарцуулах, газрын менежментийн хуулийн нөлөөлөл, лоббиг эрчимжүүлэх, байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүдийн эрх, үүрэг, эрх мэдэл, түүний дотор БАХ, УАБ-үүдтэй байгуулж буй газар ашиглалтын гэрээний асуудлыг тодорхой тусгах талаар хамтын ажиллагааны шинэ стратеги дэх Засаглалын үндсэн чиглэлтэй идэвхтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлнэ.

## 5.2 Мэргэжлийн боловсрол, сургалт

**МБС-ын тэргүүлэх чиглэлд хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг дээшлүүлэхийг зорьж байна.**

МБС-д хамрагдсан залуусын ажил эрхлэх боломжийг сайжруулах зорилгоор баруун бүсийн зургаан аймгийн сургуулиудын сургалтын хөтөлбөрийг эрэлтэд үндэслэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хувийн хэвшлийн байгууллагуудтай түншилж ажиллах замаар МБС-ыг дадлагад илүү ойр, хөдөлмөрийн зах зээлтэй уялдаатай болгож хөгжүүлнэ. Баруун аймгуудад хийсэн салбарын эрэлт хэрэгцээний судалгаанд тулгуурлан МБС-ын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд барилга, ХАА, механикийн салбар тус тус багтаж байна. Эдгээр салбар нь хөдөөгийн мэргэжилтэй залуусыг ажил эрхлэх боломжоор хангах юм.

**Зах зээлд эрэлт хэрэгцээтэй ур чадвараар дутмаг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг ур чадвар олгох богино хугацааны сургалтад хамруулах, тэдний ажил эрхлэх боломжийг дээшлүүлэх замаар МБС-ийн хөгжилд түлхэц үзүүлнэ.** Ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр ШХА-аас үзүүлэх дэмжлэг нь нас болон бусад шалтгаанаар албан ёсны МБС-д хамрагдаж чадахгүй байгаа дунд насны малчид, малчин байсан иргэдэд голчлон чиглэнэ. Мөн хөгжлийн хамтын ажиллагааны бусад түншүүд, ялангуяа АХБ, Германы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ГОУХАА)-тай хамтарч санхүүжүүлэх боломжийг эрэлхийлнэ.



**Бизнес анхлан эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх, зээл авах боломжийг нэмэгдүүлэх замаар жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн хөгжлийг дэмжинэ.**

“Голланд өвчин”-ий сөрөг нөлөөг эс тооцвол ач холбогдолтой, өрсөлдөх чадвартай хэвээр байж чадах зорилтот зах зээлд чиглэсэн ЖДҮ-үүдэд ШХА туслалцаа үзүүлнэ. Мөн МБС болон ЖДҮ-ийн төслүүдийг хамтын уялдаатай хөгжүүлэхийг зорих болно. Үүний тулд МБС-д хамрагдах оюутан залуус, залуу мэргэжилтнүүдийн техникийн боловсролд хувь нэмрээ оруулах хүсэлтэй, хариуцлагатай бизнес эрхлэгчдээр дамжуулан хэрэгжүүлнэ.

**Шинжлэх ухаанч боловсрол, амьдрах ухааны ур чадварыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулснаар Монгол залуусын экологийн боловсрол, ирээдүйд ажил эрхлэх боломжийг дээшлүүлнэ.**

ШХА нь бага болон дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт байгаль орчны боловсролыг өргөн хүрээтэй тусган оруулахыг зорьж ажиллах юм. Энэ нь экологийн боловсролд өргөн хүрээтэй, урт хугацааны өөрчлөлт гаргах хамгийн үр дүнтэй арга гэж үзэж байна. Түүнчлэн залуусын амьдрах чадварыг дээшлүүлэх, тэднийг иргэний эрхээ эдлэхтэй холбоотой гомдол гаргах, үүргээ биелүүлдэг болгож сургах зорилгоор ШХА-аас НҮБ-ын Хүн амын сангийн төсөлд дэмжлэг үзүүлнэ.

### **5.3 Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо**

**Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцооны чиглэлд Швейцарийн Засгийн газраас үр нөлөөтэй, үр ашигтай, тэгш, шударга засаглалыг орон нутагт хөгжүүлэх, иргэдийн сэтгэл ханамж, жинхэнэ төлөөлөл бүхий үр дүнтэй ИНБ-уудыг хөхиүлэн дэмжинэ.**

Засаглалын үндсэн чиглэл нь орон нутгийн засаглалын шинэтгэл ба иргэний нийгмийн хөгжлийн үр дүнгээр тодорхойлогдоно. Эдгээр нь (i) орон нутгийн захиргааны үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг сайжруулах, (ii) иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх явдал юм. Орон нутгийн захиргаа ба иргэдийн эрх мэдлийг дээшлүүлэх нь эрх тэгш нийгмийн хөгжлийн нэг урьдач нөхцөл болдог. Удирдлага сайтай, жинхэнэ төлөөлөлтэй ИНБ-ууд олон нийтийн хяналт хийх эрхэм зорилгоо сайн биелүүлж чадна.



**ШХА-ын ЗДТСХ орон нутгийн захиргааны шинэтгэлийн хэд хэдэн чухал асуудлаар дэмжлэг үзүүлнэ.** Тус хөтөлбөр нь төвлөрлийг сааруулах шинэтгэлийг төсөв санхүү, улс төр, захиргааны олон чухал талаас нь авч үзэж, зохих дэмжлэг үзүүлнэ. Үүнд Төсөв санхүүгийн хувьд оролцоот төлөвлөлт ба төсөвлөлт, орон нутгийн худалдан авах ажиллагааг бэхжүүлэх бол улс төрийн хувьд иргэний оролцоот туршилтын төсөл, нийгмийн хариуцлагын хэрэгслүүдээр дамжуулан дэмжинэ. Захиргааны тухайд ШХА-ийн НЦҮ төслийн туршлагад тулгуурлан төрийн захиргааны үйлчилгээг шинэлэг арга замаар үзүүлэх гарц олох асуудлыг авч үзнэ. Цаашилбал бүхий л үйл ажиллагаагаа зорилтот бодлогын дэмжлэг, судалгааны ажилд тулгуурлаж явуулна.

**ЗДТСХ-ийн үзэл баримтлалын хүрээнд олон тооны стратегийн түнш байгууллагатай хамтарч ажиллах замаар орон нутгийн засаглалын шинэтгэлд оруулах хувь нэмрээ нэмэгдүүлнэ.** ШХА нь Дэлхийн Банкнаас хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа” төсөл (ТАТ)-ийн III үе шатыг хамтран санхүүжүүлснээр Монгол Улсын төсвийн шинэ хуульд заасан төсвийн төвлөрлийг сааруулах шинэтгэлийн үр нөлөөтэй хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. Мөн НҮБХХ-ийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төсөлд хувь нэмэр оруулснаар орон нутгийн хурлууд төлөөллийн болон хяналтын үүргээ биелүүлж, орон нутгийн үйлчилгээг үр нөлөөтэй,

хүртээмжтэй, хариуцлагатай болгох боломж олгоно. Мөн энэ төслөөс эмэгтэй улс төрчдийн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд, нийгмийн бусад эмзэг бүлгийн дуу хоолойг нэмэгдүүлнэ.

**Иргэний нийгмийн хөгжилд оролцох оролцоогоо нэмэгдүүлэх замаар Монголын ИНБ-уудын алдаа дутагдлыг шийдвэрлэхэд тусална.** Удирдлага, зохион байгуулалт сайтай ИНБ-ууд нь гишүүдийнхээ ашиг сонирхлыг төлөөлөх, иргэд үндсэн эрхээ эдлэх, дуу хоолойгоо илэрхийлэхийг дэмжих чадвар сайтай байж, төрийн албан тушаалтнууд, сонгуульт төлөөлөгчидтэй хариуцлага тооцож чаддаг. Монголд хийсэн судалгаагаар ТББ-уудад олон талын саад бэрхшээл тулгардгийг тогтоосны дотор иргэдийн оролцоо, иргэний боловсрол, ил тод байдал дутагддаг байна. Түүнчлэн авлига, олигархи хүчнүүдийн нөлөө зэрэг хүчин зүйл нөлөөлдгийг дурджээ. Мөн ТББ-уудын удирдлага, засаглалд дотоод ардчилал, санхүүгийн ил тод байдал дутагддаг болохыг уг судалгаагаар тогтоосон байна. ШХА-аас Дэлхийн Банктай хамтран хэрэгжүүлсэн “ТББ-ын чадавхийг бэхжүүлэх” төслийнхөө туршлагад тулгуурлан 2013-2016 онд энэ чиглэлээр үзүүлэх дэмжлэгээ өргөтгөж, ИНБ-уудын нөлөөлөл, олон нийтийн хяналтын чиг үүргийг бэхжүүлэхэд анхаарч ажиллана.

## 6. Төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэх менежмент

**Монгол Улсын хөгжлийн нөхцөл байдал эрчимтэй хувьсан өөрчлөгдөж, төсвийн хөрөнгө хурдацтай нэмэгдэж байгаа нөхцөлд үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулж, үндэсний тогтолцоонд тулгуурлан ажиллах явдал чухал.** Энэхүү арга барил нь: (i) тус хөтөлбөрөөс Засгийн газар анхааралдаа авч санхүүжүүлэх магадлал өндөртэй сэдвүүдэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ, (ii) Швейцарь Улс бүхий л оролцоондоо хамтын төлөвлөлт, хамтын хэрэгжүүлэлт, хамтын санхүүжилт, хамтын үнэлгээг шаардана, (iii) төсвийн хөрөнгийг ядууст ашиг тусаа өгөхүйц тэргүүлэх чиглэл, үйлчилгээнд чиглүүлдэг байх ардчилсан механизмыг бэхжүүлнэ, (iv) хөшүүрэг бий болгох, үндэсний тогтолцоог ашиглах үүднээс олон талт түншүүдтэй хамтарсан төслийг илүүтэй дэмжинэ, (v) ШХА-ийн өөрөө төсөл хэрэгжүүлэх механизмыг дуусгавар болгох гэсэн зорилтуудад нийцнэ.

**Швейцарь Улс болон ШХА-ийн төсөл хөтөлбөрийн хувьд бодлогын болон техникийн чанартай зөвлөгөөгөөр хангаж чадах чиглэлүүдэд бодлогын яриа хэлэлцээг төвлөрүүлнэ.** Швейцарь Улсаас Монголд харьцангуй давуу тал бий болгохоор хүлээн зөвшөөрөгдсөн чиглэлүүдэд: (i) байгалийн нөөцийн тогтвортой удирдлага; (ii) малын эрүүл мэнд, МАА-н үйлдвэрлэл, маркетингийн тогтолцоо; (iii) ЖДҮ-ийн хөгжилтэй уялдуулсан МБС; (iv) төвлөрлийг сааруулах, ардчилах үйл явц; (v) иргэний нийгмийг бэхжүүлэх явдал орж байна. Туршлагаас үзэхэд бодлогын яриа хэлэлцээрийг орон нутгийн оролцогчдын тусламжтай газар дээр нь практикт хэрэгжүүлэхдээ олон улсын тэргүүлэх зэргийн мэргэжилтнүүдийн мэдлэг туршлагатай хослуулсан нөхцөлд хамгийн үр дүнтэй байх болно.

**Хөтөлбөр нь Монгол, Швейцарийн болон олон улсын чадварлаг түншүүдтэй идэвхтэй хамтран ажиллана.** ХАА, хүнсний аюулгүй байдлын чиглэлд Монголын талаас Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (ҮХААЯ), Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ) гол түнш байх юм. Швейцарийн хувьд Агроскоп, Цюрихийн технологийн их сургууль, Швейцарийн Нийтийн эрүүл мэндийн хүрээлэн, Холбооны мал эмнэлгийн газар, Бернийн их сургууль, Аюулгүй хүнсний шийдэл байгууллага тус тус болно. МБС-ын чиглэлээр Монгол Улсын Хөдөлмөрийн яам (ХЯ), Боловсролын яамтай голлон хамтран ажиллана. Засаглалын тухайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Ерөнхийлөгчийн тамгын газар зэрэг байгууллага байх юм. Швейцарийн зүгээс Аарау дахь Ардчилал судлалын төв, Люцернийн их сургууль хамтран ажиллана. Түүнчлэн ШХА-аас Дэлхийн Банк, НҮБ-тай хамтран ажиллаж, АХБ, Европын холбоо (ЕХ)-ны төлөөлөгч, Австрали, Канад, Герман, Япон, Солонгос болон АНУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлагуудтай үйл ажиллагаагаа бүх талаар уялдуулж ажиллана. Мөн хөгжлийн тусламжийг уялдуулан зохицуулах албан ёсны механизмуудыг дэмжиж, оролцож ажиллах болно.

**Хөтөлбөрийн санхүүжилтын хэмжээ 2015 онд оргил үедээ хүрч жилийн 22 сая шв.франк болох бөгөөд түүнээс хойш аажмаар буурч 2020 онд дуусгавар болно.**

Төлөвлөсөн төсвийн 80-аас доошгүй хувийг хамтын ажиллагааны стратегийн гурван үндсэн чиглэлд зарцуулна. Нэмэлт санхүүжилтыг МБС, засаглалын чиглэлийн олон талт чадварлаг байгууллагуудтай стратегийн, идэвхтэй түншлэл явуулахад хөрөнгө оруулна. Хэд хэдэн үе шаттай 3-12 сая шв.франкын санхүүжилт бүхий томоохон, өргөн хүрээтэй, стратегийн төслүүдийг 2015 он хүртэл хэрэгжүүлнэ. 2016 он гэхэд ихэнх төслийн хэрэгжүүлэгчийг өрсөлдөөнт нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгосон байна.

**Швейцарийн хамтын ажиллагааны газрын хариуцлага нэмэгдэж, ажил үүргийн хүрээ өргөжинө.** Тус газрыг Суурин төлөөлөгч буюу ерөнхий консул удирдана. Түүний удирдлаган дор дэд суурин төлөөлөгч, хөтөлбөрийн менежер (2013 оны дундаас), санхүү, захиргааны албаны дарга, үндэсний хөтөлбөрийн ажилтнууд болон дэмжлэг үзүүлэх баг ажилладаг. Түүнчлэн товлосон чиглэлээр гадаад зөвлөхүүд ажиллаж байна. ШХА-ийн төвлөрлийг сааруулах дотоод шинэтгэл, санхүүжилтын огцом өсөлтөөс шалтгаалан хамтын ажиллагааны газрын санхүү, захиргааны хариуцлага, ажил үүрэг, хөтөлбөрийн багийн эрэлт ихсэж байна. Хамтын ажиллагааны стратегийн дараагийн үед төслийн менежментийн бүхий л чиглэлээр ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх шаардлагатай болно.



### Төлөвлөсөн зарцуулалт (сая шв. франк)

Үндсэн чиглэл	2013	2014	2015	2016	Нийт	%
ХАА, хүнсний аюулгүй байдал	6.6	5.9	6.2	6.0	24.7	31
Мэргэжлийн боловсрол, сургалт	2.0	3.4	4.6	4.9	14.9	19
Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо	4.0	7.2	7.2	7.2	25.6	32
Бусад төсөл	2.1	3.3	3.3	3.0	11.7	14
Нийт санхүүжилт	14.7	19.8	21.3	21.1	76.9	96
ШХА-ны газар (гадаад мэргэжилтний цалинг оруулаагүй)	0.8	0.8	0.8	0.8	3.2	4
<b>Нийт</b>	<b>15.5</b>	<b>20.6</b>	<b>22.1</b>	<b>21.9</b>	<b>80.1</b>	<b>100</b>



# 7. Удирдлагын стратеги

**Хамтын ажиллагааны стратегид системтэй хяналт шинжилгээ хийснээр хөтөлбөрийг удирдлагын стратегиэр хангах боломжтой болно.** Төсөл хөтөлбөрийн ач холбогдол, үр ашигтай байдлыг тасралтгүй хангах, хүрсэн үр дүнг баталгаажуулах, хяналт шинжилгээний үйл явцаар дамжуулан бүхий л шатанд тогтмол суралцахад удирдлагын стратеги зайлшгүй шаардлагатай. Хяналт шинжилгээний ажилд Швейцарийн хамтын ажиллагааны газар, бүх төслийн ажилтнуудыг идэвхтэй татан оролцуулна. Түүнчлэн хяналт шинжилгээний систем нь ажилтнуудын төслийн менежментийн чадавхийг сайжруулах, хөтөлбөр үр дүнд чиглэх нөхцлөөр хангах зорилготой.

**Хөтөлбөрийн хэрэгжилт, оролцоо бүрийг үр дүнгийн хүрээний хэрэгслээр дамжуулан төлөвлөж, удирдаж, хянана.** Хамтын ажиллагааны шинэ стратеги боловсруулах үеэр гаргасан үр дүнгийн хүрээнд гурван үндсэн чиглэлийн хүрээнд гарах үр дүнг улсын түвшинд болон Швейцарийн хамтын ажиллагааны түвшинд тодорхойлсон. Улсын түвшинд гарах үр дүнгүүдийг онцолж, тэдгээрт хүрэхэд Швейцарийн хамтын ажиллагааны оруулах хувь нэмрийг харуулах байдлаар үр дүнгийн хүрээг боловсруулсан юм. Энэ арга нь улсын болон Швейцарийн хамтын ажиллагааны түвшинд ажиглагдсан өөрчлөлтийг нягт уялдуулж, бүхий л үйл ажиллагааг үр дүнгийн түвшнээс үр нөлөөний түвшинд шилжүүлэхэд чиглэнэ. Улсын түвшний тоо баримтыг гол төлөв Үндэсний статистикийн газар (ҮСГ)-ын болон Засгийн газрын бусад эх сурвалжаас авна.

**Швейцарийн хамтын ажиллагааны газар нь онцгой ач холбогдол бүхий цөөн тооны үзүүлэлтэд тулгуурласан нийцтэй, мэдээллийн технологид суурилсан хяналт шинжилгээний тогтолцоо бий болгохыг эрмэлзэнэ.** Улсын болон Швейцарийн хамтын

ажиллагааны түвшин тус бүрт 15 үзүүлэлт бүхий долоон үр дүнг, нийтдээ 30 үзүүлэлт, 14 үр дүнг хэмжинэ. Улсын түвшний үр дүнг МХЗ-д тулгуурласан 2007-2020 оны ҮХЦБ-ын үр дүнгээс авах юм. Үзүүлэлтүүдийн тоо баримтыг ҮСГ, Засгийн газрын болон олон улсын бусад байгууллагын эх сурвалжаас авна. Швейцарийн хамтын ажиллагааны түвшний тоо баримтыг хоёр эх сурвалжаас бүрдүүлэх юм. Ингэхдээ ихэнх үзүүлэлтийг төслөөс гаргасан тоо баримтаас авахын зэрэгцээ Швейцарийн хамтын ажиллагааны газраас сонгосон чиглэлээр жил бүр судалгаа явуулна.

**Тоо баримтыг жилд нэг удаа нэгтгэн цуглуулж, ШХА-ийн үйл ажиллагааны жилийн тайланд тусгана.** Швейцарийн санхүүжилттэй төсөл, судалгаанд мэдээлэл цуглуулах үүднээс жил бүрийн эхний хагас жилийн төгсгөлд албан ёсны ДХҮ хийж, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавина. Түүнчлэн жил бүрийн судалгаа болон төслүүдээс авсан үр дүнгийн мэдээллийг Хөгжлийн холбогдолтой өөрчлөлтүүдийн хяналтын систем (ХХӨХС)-ийн талаарх ШХА-ийн тайлантай нэгтгэн жилийн тайланд оруулна. Менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалт нь төлөвлөсний дагуу Швейцарийн хамтын ажиллагааны үр дүнг дэмжиж, улсын түвшний үр дүнд хувь нэмэр оруулах эсэхийг нягтална. Жилийн тайлангаас гадна гол үр дүнг Швейцарийн хамтын ажиллагааны газрын сар тутмын сонин, дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон ШХА-ийн “Asia Briefs” сэтгүүлд нийтэлнэ. Мөн ШХА-ийн Үе шатны төгсгөлийн тайланд төсөл, хөтөлбөрийн үе шат бүрт сурч мэдсэн зүйлсийг тусгах замаар стратегийн удирдлагад чухал хувь нэмэр оруулна. Дор үзүүлсэн бүдүүвч зурагт үндсэн чиглэл бүрийн улсын түвшний болон Швейцарийн хамтын ажиллагааны түвшний үзүүлэлтийг олж авах эх үүсвэр, хугацааг харуулав.

Улсын болон Швейцарийн хамтын ажиллагааны түвшний үзүүлэлтийн эх сурвалж, цуглуулах хугацаа

Улсын түвшний үзүүлэлтүүд

ҮСГ-ын үзүүлэлтүүд					ҮХААЯ	3	6	ХЯ	11
1	2	4	5	7	Есдүгээр сар	дөчт	12	дзү	14
8	9	10	13	Цахим худалдан авалт		15			
ХХӨХС									

Швейцарийн хамтын ажиллагааны түвшний үзүүлэлтүүд

Жил бүрийн судалгаа			Төслийн тоо баримт				
1	2	3	Есдүгээр сар	5	7	9	13
4	6	8		10	11	12	14
							15

1	Үзүүлэлт #		ХАА болон ХАБ-ын салбар		МБС		Засаглал
---	------------	--	-------------------------	--	-----	--	----------

# Хавсралт 1: Хамтын ажиллагааны стратеги товчоор

<b>Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2016 оны стратегийн ерөнхий агуулга</b>		
<b>Ерөнхий зорилго</b>		
Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах		
<b>Дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл</b>		
ХАА, хүнсний аюулгүй байдал	Мэргэжлийн боловсрол, сургалт	Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо
Жендерийн тэгш байдал- нийтлэг сэдэв		
<b>Үндсэн чиглэлийн зорилго</b>		
Хөдөөгийн хүн амын эмзэг бүлгийн орлого, амьжиргааг дээшлүүлэх	Хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг дээшлүүлэх	Үр нөлөөтэй, ашигтай, тэгш, шударга засаглалыг орон нутагт хөгжүүлэх, жинхэнэ төлөөлөл бүхий үр дүнтэй ИНБ-уудыг хөхиүлэн дэмжих
<b>Швейцарийн талаас оруулах хувь нэмэр</b>		
Малчин, тариаланч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх Малчин, тариаланч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн зах зээлийн боломжийг сайжруулах Малчин, тариаланч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн амьжиргааны баталгааг сайжруулах	МБС-т хамрагдсан залуусын ажил эрхлэх боломжийг сайжруулах Зах зээлд хэрэгцээтэй үр чадвар дутмаг залуусыг богино хугацаанд сургах, ажил эрхлэх боломжийг дээшлүүлэх	Орон нутгийн захиргааны үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг сайжруулах ИНБ-уудын чадавхи, нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх
<b>Төсөв</b>		
24.7 сая шв.франк	14.9 сая шв.франк	25.6 сая шв.франк

# Хавсралт 2: Үр дүнгийн хүрээ

Стратегийн зорилго: Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах

Дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл 1: ХАА, хүнсний аюулгүй байдал		
Үндсэн чиглэлийн зорилго: Хөдөөгийн хүн амын эмзэг бүлгийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг дээшлүүлэх		
(1) Швейцарийн менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтын үр дүн	(2) Швейцарийн хөтөлбөрийн оруулах хувь нэмэр	(3) Монгол Улсын хөгжлийн үр дүнгүүд <sup>1</sup>
<p>Үр дүнгийн тодорхойлолт 1: Хөдөлмөрийн бүтээмж: Малчин, тариаланчдын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах (эр/эм). (Газар зүйн зорилтот бүс: улсын болон орон нутгийн хэмжээнд -&gt;баруун, төвийн бүсийн аймгууд)</p> <p>Үзүүлэлтүүд:</p> <p>1) Төмсний ургац (тонн/га) (Эх сурвалж: Усны нэгдсэн менежментийн төсөл (УНМТ), “Монгол төмс” хөтөлбөрт, хамрагдагсдын жилийн судалгаа)</p> <p>2) Хүнсний ногооны ургац (тонн/га) (Эх сурвалж: УНМТ, “Монгол төмс” хөтөлбөрт хамрагдагсдын жилийн судалгаа)</p> <p>3.ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний ашиг тусын тухай ойлголт: эр/эм (Эх сурвалж: “Ногоон алт” төслийн үр шимийг хүртэгсдийн жилийн судалгаа)</p>	<p>Үр нөлөөний таамаглал: Цаг агаарын тааламжтай нөхцөлд тариаланчид шаардагдах мэдлэг, чадвартай, ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний нэгж үр дүнтэй ажиллаж, бусад холбогдох байгууллагууд зохих ёсоор ажиллаж байгаа тохиолдолд хөдөлмөрийн бүтээмж дээшилнэ.</p> <p>Завсрын үр дүнгүүд: 1. Хөдөөгийн малчид, тариаланчид, бизнес эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үр ашигтай, үр нөлөөтэй загварыг ШХА-ийн дэмжлэгтэйгээр хөгжүүлж, Засгийн газрын шугамаар түгээн дэлгэрүүлсэн байна. 2. Шүлхий, бруцеллэз өвчний хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бий болгож хэрэгжүүлсэн байна. Эрсдэл: Бодлого зохицуулалт, хууль журмыг сайн хэрэгжүүлэх, сахин биелүүлэх сонирхолгүй нөхцөлд бэлчээрийн доройтол үргэлжлэх.</p>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 1: Хөдөлмөрийн бүтээмж Газар тариаланг сайжруулж, услалттай тариалалт хөгжүүлэх, биотехнологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ</p> <p>Малын халдварт өвчин дэгдэлт, тархалтыг бодитойгоор бууруулж мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ</p> <p>(ҮХЦБ (2007-2015) 5.2.1.4. Стратегийн зорилт 1 ба 2)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд: 1)Төмсний ургац, улсын дундаж (тонн/га), (ҮСГ) 2) Хүнсний ногооны ургац, улсын дундаж (тонн/га), (ҮСГ) 3) ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний сургалтад төсвөөс хуваарилсан хөрөнгө (ҮХААЯ)</p>
<p>Үр дүнгийн тодорхойлолт 2: Зах зээлийн боломж: Малчид, тариаланчдын (эр/эм) зах зээлийн боломжийг сайжруулах. (Газар зүйн зорилтот бүс: улсын болон орон нутгийн хэмжээнд -&gt;баруун, төвийн бүсийн аймгууд)</p> <p>Үзүүлэлтүүд:</p> <p>4) Тариаланчдын орлогын өөрчлөлт: эм/эр (Эх сурвалж: Усны нэгдсэн менежментийн төсөл, “Монгол төмс” хөтөлбөрт хамрагдагсдын жилийн судалгаа)</p> <p>5) Хоршоодын дундын өмчийн хэмжээнд гарсан өөрчлөлт (Эх сурвалж: “Ногоон алт” төсөлд хамрагдагсдын жилийн судалгаа)</p>	<p>Үр нөлөөний таамаглал: Ядуусыг хамруулсан хамтын ажиллагааны байгууллагууд эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, илүү сайн нөхцлөөр бизнесийн тохиролцоо хийх, анхан ба дунд шатны чанартай бүтээгдэхүүн гаргах, зах зээлийн хэлхээ холбоогоо сайжруулах, илүү их орлого бий болгох боломжтой.</p> <p>Завсрын үр дүнгүүд: 1. Дотоодын болон олон улсын нэмүү өртгийн сүлжээнд ахицтай ажиллах хэмжээнд БАХ-үүд, УАБ-үүд болон хоршоодын чадавхийг бэхжүүлэх,. 2. Сонгож авсан (хожим тодорхойлох) нэр төрлийн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг сайжруулж, ядуусын орлогыг нэмэгдүүлнэ. Эрсдэл: 1. Тогтворгүй загвар бүхий хоршоодод улсын төсвийн татаас хүрэхгүй байх, хоршооны хөдөлгөөн жинхэнэ ёсоор өрнөхгүй байх.</p>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 2</p> <p>Хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах, олон улсын зах зээлд өрсөлдөх хэмжээнд үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ</p> <p>Хоршоо, эвлэл, экспорт, импортын банк гэх мэт экспортын үйлдвэрлэлийг дэмжих төрөлжсөн байгууллагууд байгуулж, дэмжлэг үзүүлнэ</p> <p>(ҮХЦБ 5.2.1.2., ҮХЦБ 5.1.3., ҮХЦБ, 5.2.1.4)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд</p> <p>4) Нэг хүнд ногдох хүнсний ногооны хэрэглээ, улсын дундаж (кг), (ҮСГ)</p> <p>5) ХАА-н салбар дахь хоршоодын хөрөнгийн эзлэх хувь, (ҮСГ)</p>

<sup>1</sup> Монгол Улсын хөгжлийн үр дүнгүүдийн жендэрийн мэдрэмж: ШХА гол төлөв технологийн чиглэлээр ажиллаж байгаа учир ҮСГ-аас хүйсээр задалсан тоо баримт гаргаж өгөх боломжгүй.

<p>Үр дүнгийн тодорхойлолт 3: Амьжиргаа: Малчид, тариаланчдын (эр/эм) амьжиргааны баталгааг сайжруулах (Газар зүйн зорилтот бүс: улсын болон орон нутгийн хэмжээнд -&gt;баруун болон төвийн бүсийн аймгууд)</p> <p>Үзүүлэлтүүд:</p> <p>6) Газар тариалангийн баталгаатай усан хангамж бүхий тариаланч өрхийн эзлэх хувь: эр/эм</p> <p>(Эх сурвалж: УНМТ, “Монгол төмс” хөтөлбөрт хамрагдагсдын жилийн судалгаа)</p> <p>7) Малын даатгалын схемд хамрагдсан малчин өрхийн эзлэх хувь: эр/эм (Эх сурвалж: “Малын индексжүүлсэн даатгал” төсөл)</p> <p>8) Малын тоо толгой бэлчээрийн даацад тохирч байгаа эсэх тухай малчдын ойлголт (Эх сурвалж: “Ногоон алт” төсөлд хамрагдагсдын жилийн судалгаа)</p>	<p>Үр нөлөөний таамаглал: Мал сүргээ даатгуулсан, татаасыг зорилтот бүлэгт зөв чиглүүлсэн, байгалийн нөөцийн тогтвортой менежментийн урт хугацааны арга хэмжээ, эзэмших эрхийг хуульчилсан тохиолдолд хөдөөгийн иргэдийн амьжиргаа илүү баталгаажна.</p> <p>Завсрын үр дүнгүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Экологийн баримжаатай, чадамжид тулгуурласан бэлчээрийн эрүүл мэндийн хяналт, удирдлагыг нэвтрүүлнэ.</li> <li>2. Хамтын ажиллагааны байгууллагууд сумдад бэлчээр эзэмших эрхээ баталгаажуулсан байна.</li> <li>3. Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хөхиүлэн дэмжихүйц ХАА-н зорилтот татаасын механизм бий болсон байна</li> </ol> <p>Эрсдэл:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутагт БАХ-үүд бэлчээр эзэмших эрхийг дэмжсэн бодлогоор дутагдах</li> <li>2. Одоогийн зохицуулалтуудыг даган биелүүлэхгүй байх.</li> </ol>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 3 Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулна.</p> <p>Газар болон ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглуулах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ</p> <p>(ҮХЦБ 6. Стратегийн зорилт 2 &amp; 7.1. Стратегийн зорилт 2)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>6) Услалттай тариалангийн талбайн хэмжээ (га), (ҮСГ)</li> <li>7) Малын хорогдол, (ҮСГ)</li> <li>8) Амины малын тоо, (ҮСГ)</li> </ol>
--	--	--

**(4) Дэмжлэг үзүүлэх шугамууд (Швейцарийн хөтөлбөр)**

<p>Үр дүн 1</p> <ul style="list-style-type: none"> <li>• Малын халдварт өвчний хяналтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр мал эмнэлгийн албанд дэмжлэг үзүүлнэ.</li> <li>• Мал эмнэлгийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, багш нарын сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.</li> <li>• Төмс, хүнсний ногооны үрийг шинэчилнэ.</li> <li>• Малчдад мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээний загвар боловсруулах, Засгийн газраас уг загварыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</li> </ul> <p>Үр дүн 2</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн бүлгүүдийг тэгш хамруулсан борлуулалтын хоршоодыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</li> <li>• Зах зээлийн тодорхой дэд салбарт нэмүү өртөг бий болгоход туслалцаа үзүүлнэ.</li> <li>• Хамтын үйл ажиллагааны тогтолцоог бэхжүүлж, бизнесийн тохиролцоо хийх чадвар, ардчилсан оролцоо, санхүүжилт авах боломжийг сайжруулна.</li> </ul> <p>Үр дүн 3</p> <ul style="list-style-type: none"> <li>• ХАА-н татаасын тогтолцоо, бэлчээрийн тухай хуулийг сайжруулах чиглэлд дүн шинжилгээ, бодлогын дэмжлэг үзүүлнэ.</li> <li>• Сумын захиргаа, БАХ-үүдийн бэлчээр эзэмших эрхийн яриа хэлэлцээг дэмжих, гамшгийн эрсдлийг бууруулах стратегийг сайжруулах, бэлчээрийн нөөцийн удирдлагын (бэлчээр, ус) арга зүйг хөгжүүлэх замаар хамтын ажиллагааг бэхжүүлнэ.</li> <li>• Бэлчээрийн нөөцийн удирдлагын хяналт шинжилгээний зохистой тогтолцоо бий болгоход дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.</li> </ul>
---

**(5) Хөрөнгө санхүүжилт, түншлэл (Швейцарийн хөтөлбөр)**

<p>Төсөв: 27.5 сая шв. франк</p> <p>ШХА-ийн хоёр талт төслүүдийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулсан байгууллагууд (ТББ, хувийн хэвшил гэх мэт) хэрэгжүүлнэ. Дэлхийн Банктай хэрэгжүүлж буй түншлэлийг (малын даатгал, тогтвортой амьжиргааны чиглэлээр ) үргэлжлүүлэн өргөжүүлнэ. Хамтран ажиллах үндэсний түншүүд: ҮХААЯ, БОНХЯ, Мал эмнэлгийн сургууль, БАХ-үүдийн Монголын холбоо, Монголын фермерүүдийн холбоо</p>
--

**Дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл 2: Мэргэжлийн боловсрол, сургалт**

**Үндсэн чиглэлийн зорилго: Хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг дээшлүүлэх**

<b>(1) Швейцарийн менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтын үр дүн</b>	<b>(2) Швейцарийн хөтөлбөрийн оруулах хувь нэмэр</b>	<b>(3) Монгол Улсын хөгжлийн үр дүнгүүд</b>
<p>Үр дүнгийн тодорхойлолт 1: МБС</p> <p>МБС-т хамрагдсан залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг сайжруулах (Газар зүйн зорилтот бүс: Баруун 6 аймаг)</p> <p>Үзүүлэлтүүд:</p> <p>9) МБС төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь: эр/эм (Эх сурвалж: МБС төсөл)</p> <p>10) Дадлагийн ба ангийн сургалтын харьцаа (Эх сурвалж: МБС төсөл)</p>	<p>Үр нөлөөний таамаглал Хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд амьдарч буй бүс нутагтаа чанар сайтай, эрэлт хэрэгцээтэй мэргэжлийн сургалтад хамрагдах боломжтой бол тухайн чиглэлээр ажилд орох нөхцөл бүрдэнэ.</p> <p>Завсрын үр дүнгүүд: 1. МБС-ын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө ажил олгогч болон зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх тогтолцоотой болно. 2. Хувийн компаниуд дадлагын сургалтын загвараар хангасан байна.</p> <p>Эрсдэл: 1. Уул уурхайн салбарын эрчимтэй хөгжлийн улмаас Монголын ЖДҮ-үүдийн өрсөлдөх чадвар буурах</p>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 1 Олон улсын арга зүй, гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн сургалтын төвүүд байгуулна</p> <p>Техник мэргэжлийн болон дээд боловсролын чанарыг сайжруулж, сургалтад хамрагдалтын төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна</p> <p>(ҮХЦБ 4.4. Стратегийн зорилго 4)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд:</p> <p>9) Техник МБС-нд хамрагдагсдын тоо, (ҮСГ) (эр/эм)</p> <p>10) Техник МБС болон дээд боловсролын байгууллагад суралцагсдын тоо, (ҮСГ) (эр/эм)</p>
<p>Үр дүнгийн тодорхойлолт 2: Зах зээлд хэрэгцээтэй үр чадвар дутагдаж буй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үр чадварыг богино хугацаанд хөгжүүлж, ажил эрхлэх боломжийг дээшлүүлэх. (Газар зүйн зорилтот бүс: тодорхойлно)</p> <p>Үзүүлэлтүүд:</p> <p>11) Богино хугацааны сургалт төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь: эр/эм</p> <p>(Эх сурвалж: Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үр чадвар хөгжүүлэх төсөл)</p>	<p>Үр нөлөөний таамаглал Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй үр чадвар олгох богино хугацааны сургалтад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг хамруулснаар хүрэлцэхүйц цалинтай, баталгаатай ажилтай болох боломжийг тэдэнд олгоно.</p> <p>Завсрын үр дүнгүүд: Албан ёсны хөтөлбөрөөр дамжуулан үр ашигтай, үр нөлөөтэй сургалт явуулна.</p> <p>Эрсдэл: 1. Нийгмийн халамжийн тэтгэмж эрс нэмэгдвэл ажилд орохын төлөө үр чадвараа дээшлүүлэх сонирхол буурч болзошгүй.</p>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 2 Эмзэг бүлгийн нэн ядуу, ажилгүй иргэдийг бүртгэж, богино хугацааны мэргэжлийн сургалтуудад хамруулан, ажил эрхлэх нөхцөл боломж бүрдүүлнэ.</p> <p>(ҮХЦБ 4.1. Стратегийн зорилго 4, ҮХЦБ 4.4 Стратегийн зорилго 5)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд: 11) ХЯ-наас богино хугацааны сургалтад зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), (ХЯ)</p>
<p><b>(4) Дэмжлэг үзүүлэх шугамууд (Швейцарийн хөтөлбөр)</b></p>		
<p>Үр дүн 1</p> <ul style="list-style-type: none"> <li>Баруун бүсийн зургаан аймгийн оюутан сурагчид, айл өрх, ажил олгогчдын дунд МБС-ын тухай эерэг ойлголт төрүүлнэ.</li> <li>Завхан аймгийн Бүсийн арга зүйн төв нь Мэргэжлийн боловсролын газрын салбар болон ажиллаж тус бүсийн МБС-ын зургаан сургуульд үйлчилж, (арга зүйн удирдамж, багш нарын сургалт, хяналт шинжилгаа, судалгаа гэх мэт) МБС-ын бодлогыг хэрэгжүүлнэ.</li> <li>МБС-ын төвүүд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан эрэлтэд чиглэсэн сургалтыг сонгосон чиглэлүүдээр явуулж туршилт хийнэ.</li> </ul> <p>Үр дүн 2</p> <ul style="list-style-type: none"> <li>Цаашид үр чадвар хөгжүүлэх төсөл хэрэгжүүлж АХБ, ГОУХАА-тай хамтран ажиллах боломжийг эрэлхийлнэ.</li> </ul>		
<p><b>(5) Хөрөнгө санхүүжилт, түншлэл (Швейцарийн хөтөлбөр)</b></p>		
<p>Төсөв: 16 сая шв. франк. Монголын МБС-ын байгууллагууд, ХЯ, Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэх мэт ТББ-уудтай хамтран МБС-нд цогц дэмжлэг үзүүлнэ. ХЯ, олон улсын түнш байгууллагуудтай хамтран үр чадвар хөгжүүлэх богино хугацааны сургалтын төсөл хэрэгжүүлнэ: АХБ, ЕХ, ГОУХАА-тай үйл ажиллагаа уялдуулж, харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэнэ.</p>		

**Дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл 3: Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо**

**Үндсэн чиглэлийн зорилго:**

Орон нутгийн захиргааны үр ашигтай, үр нөлөөтэй, тэгш шударга ажиллагаа, иргэдийн сэтгэл ханамж, ИНБ-ын жинхэнэ төлөөлөлтэй, үр нөлөөтэй байдал

<b>(1) Швейцарийн менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтын үр дүн</b>	<b>(2) Швейцарийн хөтөлбөрийн оруулах хувь нэмэр</b>	<b>(3) Монгол Улсын хөгжлийн үр дүнгүүд</b>
<p>Үр дүнгийн тодорхойлолт 1: Орон нутгийн засаглал: Орон нутгийн захиргааны үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг сайжруулах (Газар зүйн зорилтот бүс: улсын хэмжээнд)</p> <p>Үзүүлэлтүүд</p> <p>12) Орон нутгийн захиргааны үйл ажиллагааны тухай иргэдийн ойлголт: эр/эм (Эх сурвалж: ЗДТСХ)</p> <p>13) Сумын төсөв, орон нутгийн хөгжлийн төслүүдийг багийн иргэдийн саналаар хуваарилсан байдал (Эх сурвалж: ТАТ III төсөл)</p> <p>14) НЦҮ-ний төв д үйлчлүүлсэн иргэдийн тоо: эр/эм (Эх сурвалж: ЗДТСХ)</p>	<p>Үр нөлөөний таамаглал Ардчиллыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах шинэтгэлийн чиглэлээр орон нутгийн захиргаад, иргэдийн чадавхийг өргөнөөр бэхжүүлэх нь хөгжлийн үр дүнг адил тэгш, тогтвортой хүртэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад хувь нэмэр оруулна.</p> <p>Завсрын үр дүнгүүд: 1. Орон нутгийн захиргаад ардчилсан үйл явцыг даган мөрдөж хөгжүүлэн, иргэд орон нутгийн шийдвэр гаргалтад оролцоно.</p> <p>2. Орон нутгийн төлөвлөлт, төсөвлөлт, худалдан авалтын үйл ажиллагаанд ард иргэдийн бүлгүүд оролцож, орон нутгийн захиргаад төсөв санхүүгийн удирдлагын эрүүл саруул практик хэрэглэнэ.</p> <p>3. Орон нутгийн захиргааны үйлчилгээг иргэд үйлчлүүлэгсдэд ээлтэй байдлаар үзүүлэх боломжтой байна.</p> <p>Эрсдэл:</p> <p>1. Олон нийтийн дунд төрийн алба авлигад идэгдсэн гэх ойлголт төрөх нь төр засгийн хууль ёсны байдалд сөргөөр нөлөөлөх. Парламентын хүчний харьцаа эмзэг, жинхэнэ шинэтгэлийг дэмжих дэмжлэг хангалтгүйгээс төрийн байгууллагууд зохих ёсоор ажиллахад саад болж буй суурь дутагдалууд шийдвэрлэгдэхгүй үлдэх. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад ард иргэдийн эрэлт хэрэгцээнээс илүү улс төрийн намын болон бусад ашиг сонирхол давамгайлах.</p>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 1 Орон нутгийн захиргааны шийдвэрийг ил тод, иргэдийн оролцоонд тулгуурлан гаргаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.</p> <p>(ҮХЦБ: 7.2, Стратегийн зорилт 2, 7.3, Стратегийн зорилт 5)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд:</p> <p>12) Засгийн газрын бодлогын ил тод байдал, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан (ДӨЧТ)</p> <p>13) Орон нутгийн төсвийн зарлага, (ҮСГ)</p> <p>14) Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, Дэлхийн засаглалын үзүүлэлт (ДЗҮ)</p>



<p>Үр дүнгийн тодорхойлолт 2: Иргэний нийгмийн хөгжил: ИНБ-уудын чадавхи, нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх (Газар зүйн зорилтот бүс: улсын хэмжээнд)</p> <p>Үзүүлэлтүүд:</p> <p>15) Төсвөөс санхүүжилт авсан орон нутгийн ТББ-ын тоо ба гэрээний үнийн дүн (Эх сурвалж: ЗДТСХ)</p>	<p>Үр нөлөөний таамаглал Удирдлага сайтай, жинхэнэ ёсоор төлөөлөлтэй иргэний нийгмийн байгууллагууд улсын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг зорилгоо сайн биелүүлж чадна.</p> <p>Завсрын үр дүнгүүд 1. Хөдөө, хотын ИНБ-ууд дотоод засаглалын тогтолцоогоо сайжруулна. 2. ИНБ-ууд нийгмийн хариуцлагын чухал оролцогчид байна.</p> <p>Эрсдэл: 1. Засгийн газраас ИНБ-ын хөдөлгөөнийг хязгаарлах нь энэ салбарын хөгжилд саад учруулна.</p>	<p>Үр дүнгийн тодорхойлолт 2 ИНБ-ууд төрийн байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьж дуу хоолойгоо илэрхийлж, олон нийтийн чухал асуудлуудаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцоно. (ҮХЦБ 3.4)</p> <p>Улсын түвшний үзүүлэлтүүд: 15) Улсын төсвийн худалдан авалтын тендер шалгаруулалтын тоо (шинэ Засгийн газрын худалдан авалтын вэб сайт: <a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a>)</p>
--	--	--

#### **(4) Дэмжлэг үзүүлэх шугамууд (Швейцарийн хөтөлбөр)**

Үр дүн 1:  
(i) Төсөв санхүүгийн төвлөрлийг сааруулах ажиллагааг оролцоот төлөвлөлт, төсөвлөлт, орон нутгийн худалдан авалтын үйл ажиллагааг ИНБ-ын хяналттайгаар явуулах замаар хэрэгжүүлнэ; (ii) Улс төрийн төвлөрлийг сааруулах ажиллагаанд иргэний оролцоо, нийгмийн хариуцлагын асуудлыг хамруулна; (iii) Захиргааны төвлөрлийг сааруулснаар төрийн үйлчилгээний хүртээмж, хүргэлт улам сайжирна. Төсөв санхүүгийн болон улс төрийн төвлөрлийг сааруулах чиглэлд олон талт ба хоёр талт түншлэлийг Дэлхийн Банк, НҮБХХ-тэй хамтран явуулна.

Үр дүн 2:  
ШХА нь Дэлхийн Банктай хамтран ТББ-ын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төсөл үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Тус банк ТББ-уудын хариуцлагатай байдалд илүү анхаарах бол ШХА нь зохион байгуулалтын үр нөлөөтэй байдалд илүү анхаарна. Дэмжлэг үзүүлэх гуравдахь чиглэл нь Монгол Улсын хэмжээнд ИНБ-уудын ил тод, эрх тэгш байдал, нийгмийн хариуцлагыг сайжруулах жижиг төслийг дэмжих юм. ШХА-аас ТББ-ын чадавхийг бэхжүүлэх төсөл, ЗДТСХ-ийн туршлагад тулгуурлан Монгол Улсын иргэний нийгмийн салбарын хөгжилд үзүүлэх дэмжлэгээ цаашид өргөжүүлнэ.

#### **(5) Хөрөнгө санхүүжилт, түншлэл (Швейцарийн хөтөлбөр)**

Төсөв: 28.8 сая шв. франк.  
Үр дүн 1: Хамтран хэрэгжүүлэгч түншүүд: Азийн сан, Хүний аюулгүй байдлын бодлого судлалын төв, Мерси кор, Удирдлагын академи, Нирас, ТАТ (Дэлхийн банк), НҮБХХ. Үндэсний хамтрагч тал: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хүний хөгжил, Нийгмийн хамгааллын яам, Ерөнхийлөгчийн тамгийн газар.  
Хөгжлийн хамтын ажиллагааны түнш: АХБ, ЕХ, ГОУХАА, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг, Дэлхийн банк, НҮБХХ, Америкийн нэгдсэн улсын Олон улсын хамтын ажиллагаа.  
Үр дүн 2:  
Хамтран хэрэгжүүлэгч түншүүд: Монголын хөгжлийн судалгааны төв, Санхүү эдийн засгийн дээд сургууль.  
Үндэсний хамтрагч тал: Боловсролын яам, Ерөнхийлөгчийн тамгын газар

# Хавсралт 3: Үзүүлэлтүүдийн тайлбар

<b>Үзүүлэлт 1</b>	Төмсний ургац, ШХА-ийн төсөлд хамрагдагсдын дундаж (тонн/га)	<b>Улсын түвшний үзүүлэлт 1</b>	Төмсний ургац, улсын дундаж (тонн/га)
<b>Тодорхойлолт</b>	Ургац гэж тогтоосон нэгж талбай газраас хураасан ургацын дундаж хэмжээг хэлнэ. Үүнийг нэг га талбайгаас авах ургацаар хэмжинэ.	<b>Тодорхойлолт</b>	Ургац гэж тогтоосон нэгж талбай газраас хураасан ургацын дундаж хэмжээг хэлнэ. Үүнийг нэг га талбайгаас авах ургацаар хэмжинэ.
<b>2012 оны суурь үзүүлэлт</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Суурь үзүүлэлт</b>	Нэг га-гаас 13 тонн
<b>Хүрэх түвшин</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Гадны судалгаа	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ/Албан ёсны статистик тоо баримт 11-р сард бэлэн болно, ҮСГ-н 11-р сарын бюллетин/
<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын аргачлалд тулгуурлах	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын аргачлал
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 2</b>	Хүнсний ногооны ургац, ШХА-ийн төсөлд хамрагдагсдын дундаж (тонн/га)	<b>Улсын түвшний үзүүлэлт 2</b>	Хүнсний ногооны ургац, улсын дундаж (тонн/га)
<b>Тодорхойлолт</b>	Нэг га тайлбайгаас хураасан хүнсний ногооны (байцаа, манжин, лууван, сонгино, улаан лооль, сармис, өргөст хэмх, тарвас, шийгуа) хэмжээ, тонноор	<b>Тодорхойлолт</b>	Нэг га тайлбайгаас хураасан хүнсний ногооны (байцаа, манжин, лууван, сонгино, улаан лооль, сармис, өргөст хэмх, тарвас, шийгуа) хэмжээ, тонноор
<b>Суурь үзүүлэлт</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Суурь үзүүлэлт</b>	Нэг га-аас 13.7 тонн (2011)
<b>Хүрэх түвшин</b>	Суурь түвшинд тулгуурлана	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Гадны судалгаа	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын аргачлалд тулгуурлах	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ/Албан ёсны статистик тоо баримт 11-р сард бэлэн болно, ҮСГ-ын 11-р сарын бюллетин/
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 3</b>	ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний ашиг тусын тухай ойлголт: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 3</b>	ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний сургалтын хөтөлбөрт хуваарилсан төсвийн хөрөнгө
<b>Тодорхойлолт</b>	ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээнд сэтгэл ханамжтай байна гэж үнэлсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийт сургалтад хамрагдагсдын тоонд эзлэх хувь. Сэтгэл ханамжтай байдлыг "өгсөн зөвлөмжүүд нь ургац нэмэгдүүлэх болон бусад ашиг тустай байсан гэж үзсэн хүмүүс " гэж тодорхойлно.	<b>Тодорхойлолт</b>	ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн сургалтад зориулж улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
<b>Суурь үзүүлэлт</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Суурь үзүүлэлт</b>	2012 онд 30 сая төгрөг
<b>Хүрэх түвшин</b>	320 сумын нийт хүн амыг малын эмч болон ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээгээр хангана гэж үзвэл сэтгэл ханамж 60-аас доошгүй хувь байх	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Гадны судалгаа	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮХААЯ, ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын аргачлалд тулгуурлан "Ногоон алт" төсөлд хамрагдагсдын дунд түүвэр судалгаа явуулах	<b>Цуглуулах арга</b>	ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн төсөв
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 4</b>	Тариаланчдын орлогын өөрчлөлт: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 4</b>	Нэг хүнд ногдох хүнсний ногооны хэрэглээ, улсын дундаж (кг)
<b>Тодорхойлолт</b>	Эрэгтэй, эмэгтэй тариаланчдын орлогын өсөлтийг өмнөх тайлангийн үетэй харьцуулж хувиар илэрхийлнэ.	<b>Тодорхойлолт</b>	Өдөр тутам хүнсэнд хэрэглэж буй хүнсний ногооны (төмсийг оруулахгүйгээр) дундаж хэмжээг граммаар хэмжиж 365 өдрөөр үржүүлнэ.
<b>Суурь үзүүлэлт</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Суурь үзүүлэлт</b>	35.5 кг (2011)
<b>Хүрэх түвшин</b>	Суурь үзүүлэлтэд тулгуурлах	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Гадны судалгаа	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	Түүвэр судалгаа	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын аргачлал
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 5</b>	Хоршоодын дундын өмчийн хэмжээнд гарсан өөрчлөлт	<b>Улсын түвшний үзүүлэлт 5</b>	ХАА-н салбар дахь хоршоодын хөрөнгийн эзлэх хувь
<b>Тодорхойлолт</b>	Хоршоодын дундын өмчийн өсөлтийн өмнөх тайлангийн жилтэй харьцуулсан хувь. Хоршоодын үйл ажиллагааг илэрхийлэх үзүүлэлт. Хоршооны дундын өмчийн хэмжээ хоршооны чадавхийг харуулна. Сайн ажилладаг хоршоод гишүүдийнхээ тоо төдийгүй дундын өмчийнхөө хэмжээг нэмэгдүүлнэ.	<b>Тодорхойлолт</b>	ХАА-н салбарт ажиллаж буй хоршоодын хөрөнгийн хэмжээ
<b>Суурь үзүүлэлт</b>	байхгүй	<b>Суурь үзүүлэлт</b>	29'101.8 төгрөг (2011 он)
<b>Хүрэх түвшин</b>	байхгүй	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Төсөл	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ-ын статистик үзүүлэлт, Аж ахуйн нэгжийн бүртгэлийн хэсэг
<b>Цуглуулах арга</b>	"Ногоон алт" төслийн БАХ-т тулгуурласан хоршоодын данс бүртгэл	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын жилийн судалгаа
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 6</b>	Газар тариалангийн баталгаатай усан хангамж бүхий тариаланч өрхийн эзлэх хувь: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 6</b>	Услалттай тариалангийн талбайн эзлэх хувь
<b>Тодорхойлолт</b>	ШХА-ийн төсөлд хамрагдсан худаг, услалтын систем, усан сан, ус хэмнэх технологи бүхий тариаланч өрхийн (эрэгтэй, эмэгтэй өрхийн тэргүүнтэй) үнэмлэхүй тоо	<b>Тодорхойлолт</b>	Төмс, хүнсний ногооны услалттай талбайн эзлэх хувь, улсын хэмжээгээр
<b>Суурь үзүүлэлт</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Суурь үзүүлэлт</b>	9,900 га (71.5%) төмсний талбай услалттай, 7,200 га (100%) хүнсний ногооны талбай услалттай
<b>Хүрэх түвшин</b>	Суурь үзүүлэлтэд тулгуурлах	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Гадны судалгаа	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮХААЯ (ХАА Хөнгөн үйлдвэрийн яам)
<b>Цуглуулах арга</b>	Судалгааны тоо баримт цуглуулах явцад боловсруулах гадны судалгаа	<b>Цуглуулах арга</b>	ҮХААЯ
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 7</b>	Малаа даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 7</b>	Малын хорогдол
<b>Тодорхойлолт</b>	Зорилтот бүс нутгийн нийт малчин өрхөд малын даатгалын схемд хамрагдсан малчин өрхийн (эрэгтэй, эмэгтэй өрхийн тэргүүнтэй) эзлэх хувь	<b>Тодорхойлолт</b>	Байгалийн гамшиг, халдварт өвчний улмаас хорогдсон малын тоо
<b>Суурь үзүүлэлт</b>	10 %	<b>Суурь үзүүлэлт</b>	651,300 (2011 он, ҮСГ)
<b>Хүрэх түвшин</b>	15 %	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Төсөл	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	"Малын индексжүүлсэн даатгал"-ын төсөл	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 8</b>	Малын тоо толгой бэлчээрийн даацад тохирч байгаа эсэх тухай малчдын ойлголт	<b>Улсын түвшний үзүүлэлт 8</b>	Амины малын тоо
<b>Тодорхойлолт</b>	Тухайн сумын малын тоо толгой бэлчээрийн даацад тохирч байна гэж үзсэн эрэгтэй, эмэгтэй малчдын эзлэх хувь	<b>Тодорхойлолт</b>	Улсын хэмжээгээр амины өмчийн малын тоо
<b>Суурь үзүүлэлт</b>	Судалгаа хийх шаардлагатай	<b>Суурь үзүүлэлт</b>	36,335,8 (мянган толгой) (2011 ҮСГ)
<b>Хүрэх түвшин</b>	Суурь үзүүлэлтэд тулгуурлах	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Гадны судалгаа	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	"Ногоон алт" төслийн БАХ-үүдийн түүвэрт хийсэн гадны судалгаа	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 9</b>	МБС-д хамрагдсан төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 9</b>	Техник МБС-нд хамрагдагсдын тоо
<b>Тодорхойлолт</b>	Баруун бүсийн зургаан аймгийн МБС-ын төвүүдэд сонгосон мэргэжлээр суралцаж төгссөн нийт төгсөгчдөөс (эрэгтэй, эмэгтэй) нэг жилийн дотор ажилд орсон төгсөгчдийн эзлэх хувь	<b>Тодорхойлолт</b>	Улсын хэмжээгээр Техник МБС-ын төвүүдэд суралцсан төгсөгчдийн (эрэгтэй, эмэгтэй) эзлэх хувь, ҮСГ
<b>Суурь үзүүлэлт</b>	2012 он: (тодорхойлох)	<b>Суурь үзүүлэлт</b>	11,200 /5,300 эмэгтэй (2011)
<b>Хүрэх түвшин</b>	2013 он: нийт төгсөгчдийн 80 хувь 2014 он: нийт төгсөгчдийн 80 хувь	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Төсөл	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	Дагалдах судалгаа	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 10</b>	Дадлагын ба ангийн сургалтын харьцаа	<b>Улсын түвшний үзүүлэлт 10</b>	Техник МБС болон дээд боловсролын байгууллагад суралцагсдын тоо
<b>Тодорхойлолт</b>	Сонгосон чиглэлээр явуулж буй танхимийн онолын сургалтын оронд тухайн мэргэжлээр хувийн хэвшлийн байгууллагад дадлага хийлгэж буй сургалтын өсөлтийн хувь	<b>Тодорхойлолт</b>	Техник МБС-ын төвд суралцагч оюутны тоо ба их дээд сургууль, коллежид (хувийн ба улсын) суралцагч оюутны тоо
<b>Суурь үзүүлэлт</b>	2012: 50%	<b>Суурь үзүүлэлт</b>	48,000: 172,000 (ҮСГ)
<b>Хүрэх түвшин</b>	2013 он: (тодорхойлох)	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Төсөл	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	Төсөл	<b>Цуглуулах арга</b>	Статистикийн жилийн тайлан
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 11</b>	Богино хугацааны сургалт төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь:эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 11</b>	ХЯ-наас богино хугацааны сургалтад зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
<b>Тодорхойлолт</b>	Богино хугацааны сургалтад хамрагдсан төгсөгчдөөс гурван сарын хугацаанд сонгосон мэргэжлээр ажилд орсон, ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэй төгсөгчдийн эзлэх хувь	<b>Тодорхойлолт</b>	"Ажил эрхлэлтийг дэмжих сан"-гаас богино хугацааны сургалтад зарцуулсан төсвийн хэмжээ
<b>Суурь үзүүлэлт</b>	(жилийн эцэст тодорхойлох)	<b>Суурь үзүүлэлт</b>	2 тэрбум төгрөг (2010 он)*
<b>Хүрэх түвшин</b>	(жилийн эцэст тодорхойлох)	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	(жилийн эцэст тодорхойлох)	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ХЯ-ны тайлан
<b>Цуглуулах арга</b>	(жилийн эцэст тодорхойлох)	<b>Цуглуулах арга</b>	Хэвлэл нийтлэл
<b>Хугацааны давтамж</b>	Хагас жилд	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 12</b>	Орон нутгийн захиргааны үйл ажиллагааны тухай иргэдийн ойлголт: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 12</b>	Засгийн газрын бодлогын ил тод байдал
<b>Тодорхойлолт</b>	ШХА-ийн туршилт явагдаж буй захиргааны нэгжүүдэд орон нутгийн захиргааны үйл ажиллагааны талаар эерэг ойлголттой байгаа эрэгтэй, эмэгтэй иргэдийн эзлэх хувь	<b>Тодорхойлолт</b>	Засгийн газрын бодлогын ил тод байдлыг 1-7 оноогоор үнэлдэг бөгөөд дэлхийн 144 орны зэрэглэлд эзлэх байрыг харуулдаг.
<b>Суурь үзүүлэлт</b>	2012 он: (жилийн эцэст тодорхойлох)	<b>Суурь үзүүлэлт</b>	3.9 оноо авч 144 орноос 102-р байр эзэлсэн
<b>Хүрэх түвшин</b>	2013: тодорхойлох	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ЗДТСХ, Бүрэлдэхүүн хэсэг 3 (Азийн сангийн хэрэгжүүлж буй)	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ДӨЧТ
<b>Цуглуулах арга</b>	Орон нутгийн засаглалын үнэлгээ болон ЗДТСХ-ийн 3-р бүрэлдэхүүн хэсгийн суурь ба дагалдах судалгаа (хэрэгжүүлэгч Азийн сан)	<b>Цуглуулах арга</b>	Эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлгээ
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 13</b>	Сумын төсөв, орон нутгийн хөгжлийн төслүүдийг багийн иргэдийн саналаар хуваарилсан байдал	<b>Улсын түвшний үзүүлэлт 13</b>	Орон нутгийн төсвийн зарлага
<b>Тодорхойлолт</b>	Сумын төсөв, багийн иргэдийн саналд шинжилгээ хийх замаар тодорхойлсон сумын хөрөнгө оруулалтын төсөвт багийн иргэдийн саналд зарцуулсан төсвийн эзлэх хувь	<b>Тодорхойлолт</b>	Улсын төсвийн нийт зарлагад орон нутгийн төсвийн эзлэх хувь
<b>Суурь үзүүлэлт</b>	2012: 0%	<b>Суурь үзүүлэлт</b>	10.9%
<b>Хүрэх түвшин</b>	2013 он: 50% 2014 он: 60% 2015 он: 70% 2016 он: 75%	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	TAT III	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	ҮСГ
<b>Цуглуулах арга</b>	TAT III жилийн хяналтын тайлан	<b>Цуглуулах арга</b>	ҮСГ-ын статистик үзүүлэлт
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 14</b>	НЦҮ-ний төвд үйлчлүүлсэн иргэдийн тоо: эр/эм	<b>Улсын түвшний үзүүлэлт 14</b>	Засгийн газрын үр нөлөөтэй байдал: төрийн үйлчилгээ, төрийн албаны чанарын талаарх иргэдийн ойлголт
<b>Тодорхойлолт</b>	Хот, хөдөөгийн НЦҮ-ний төвүүдээр жилд үйлчлүүлж буй эрэгтэй, эмэгтэй иргэдийн тоо	<b>Тодорхойлолт</b>	Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээ, ойролцоогоор -2.5 (сул)-аас 2.5 (хүчтэй) оноогоор хэмжигддэг
<b>Суурь үзүүлэлт</b>	2012: (өргөн хүрээтэй судалгаагаар тодорхойлох)	<b>Суурь үзүүлэлт</b>	Утга -0.62 (2011)
<b>Хүрэх түвшин</b>	2013 он: (тодорхойлох) 2014 он: (тодорхойлох)	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Төсөл	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Дэлхийн Банк
<b>Цуглуулах арга</b>	ЗДТСХ, Бүрэлдэхүүн хэсэг 4 (хэрэгжүүлэгч Хүний аюулгүй байдлын судалгааны төв)	<b>Цуглуулах арга</b>	ДЗҮ-үүд
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

<b>Үзүүлэлт 15</b>	Төсвөөс санхүүжилт авсан орон нутгийн ТББ-ын тоо ба гэрээний үнийн нийт дүн	<b>Улсын түвшний үзүүлэлт 15</b>	Улсын төсвийн худалдан авалтын тендер шалгаруулалтын тоо
<b>Тодорхойлолт</b>	ЗДТСХ-ийн II бүрэлдэхүүн хэсгийн дагуу төсвийн худалдан авалтын журмаар орон нутгийн ТББ-тай байгуулсан гэрээний тоо, санхүүжилтын нийт дүн, шв. франкаар	<b>Тодорхойлолт</b>	Улсын хэмжээгээр зарлагдсан улсын төсвийн тендер шалгаруулалтын тоо
<b>Суурь үзүүлэлт</b>	13 гэрээ, 44,769 шв. франк (2011)	<b>Суурь үзүүлэлт</b>	1882 (2012 оны 10 сар)
<b>Хүрэх түвшин</b>	85 (2015)	<b>Хүрэх түвшин</b>	байхгүй
<b>Тоо баримтын эх сурвалж</b>	Төсөл	<b>Тоо баримтын эх сурвалж</b>	<a href="http://www.e-procurement.mn">http://www.e-procurement.mn</a>
<b>Цуглуулах арга</b>	ЗДТСХ, Бүрэлдэхүүн хэсэг 2 (хэрэгжүүлэгч Мерси Кор)	<b>Цуглуулах арга</b>	Гадны судалгаа <a href="http://www.e-procurement.mn">http://www.e-procurement.mn</a>
<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр	<b>Хугацааны давтамж</b>	Жил бүр

# Хавсралт 4: Хяналт шинжилгээний систем

## А. Оршил

Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2016 оны стратегийн хяналт шинжилгээний систем нь гурван зорилгод үйлчилдэг:

- ШХА-ийн менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтыг нотлох баримтад тулгуурласан удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэх;
- Хамтын ажиллагааны газраас Удирдах газарт тайлагнах үр дүнг бүртгэх;
- Төслүүд болон Швейцарийн хамтын ажиллагааны газрын бүх ажилтныг идэвхтэй татан оролцуулах замаар бүх шатанд суралцах.

Монгол дахь ШХА-ийн Хамтын ажиллагааны стратегид 2013-2016 оны хугацаанд баримтлах стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоодог. Энэхүү стратегийн ерөнхий зорилго бол Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм. Уг зорилгыг биелүүлэхийн тулд дараах харилцан уялдаатай гурван үндсэн чиглэлд ШХА-ийн дэмжлэгийг чиглүүлнэ:

<b>ҮЧ1: ХАА, хүнсний аюулгүй байдал</b>	<b>ҮЧ2: Мэргэжлийн боловсрол, сургалт</b>	<b>ҮЧ3: Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо</b>
<b>Нийтлэг сэдэв: Жендэрийн тэгш байдал</b>		

Дэмжлэгийг ҮДХ-ний хэрэгслээр дамжуулан төлөвлөж, удирдаж, хяналт тавина. Хамтын ажиллагааны стратегийг тодорхойлох явцад тогтоосон энэхүү хүрээ нь гурван үндсэн чиглэл тус бүрт:

- Улсын түвшинд хүрэх үр дүн (Монгол Улсын хэмжээний ололт амжилт);
- Швейцарийн хамтын ажиллагааны түвшинд хүрэх үр дүнг (Улсын хэмжээний үр дүнд хувь нэмэр оруулах Швейцарийн санхүүжилттэй төслүүдийн ололт амжилт) тус тус тодорхойлно.

Үр дүнгийн хүрээнд улсын түвшний долоо, Швейцарийн хамтын ажиллагааны түвшний долоон үр дүн тус тус багтаж байна. Хамтын ажиллагааны стратегийн хэрэгжилтийн явцыг хянах, тайлагнах зорилгоор боловсруулсан ҮДХ ба хяналт шинжилгээний систем нь улсын түвшний үр дүнг онцлохын зэрэгцээ Швейцарийн хамтын ажиллагааны ололт амжилтыг түүнд оруулж байгаа хувь нэмэр гэж үзэх юм. ҮДХ-ний аргачлал нь улсын болон Швейцарийн

хамтын ажиллагааны түвшний үр дүнг нэгтгэх, бүхий л үйл ажиллагааг үр дүнгийн түвшнээс үр нөлөөний түвшинд шилжүүлж харуулах зорилготой.

## Б. Бид юунд, хэрхэн хяналт шинжилгээ хийх вэ?

Хамтын ажиллагааны стратегийн хяналт шинжилгээг ҮДХ-нд дурдсаны дагуу хөтөлбөрийн гурван үндсэн чиглэл, хяналтын хоёр түвшнээр (улсын ба Швейцарийн хамтын ажиллагааны түвшний) зохион байгуулна.

Улсын түвшний хяналт шинжилгээг жилийн турш хийж, улмаар 10 дугаар сард хоёр баримт бичиг болгон нэгтгэнэ:

- ХХӨХС – Монгол Улсын ерөнхий нөхцөл байдалтай холбоотой өөрчлөлтүүдийг хянах ШХА-ийн стандарт хэрэгсэл;
- Жилийн тайлан – ШХА-аас сонгосон үзүүлэлтүүдээр дамжуулан улсын түвшний өөрчлөлтүүдийг хянах (Хавсралт 3 - Үзүүлэлтүүдийн тайлбарыг үзнэ үү)

Улсын түвшний үр дүнгүүд	
<b>Үр дүнгүүд</b>	Стратегитэй холбоотой үндэсний хэмжээний долоон үр дүнг тодорхойлсон. Үр дүнд хяналт тавихдаа дараах зүйлсийг нягтална: <ul style="list-style-type: none"> <li>• Тухайн улс тогтоосон зорилтуудаа хангах чиглэлд явж байгаа эсэх;</li> <li>• Зорилтууд хүчин төгөлдөр хэвээр байгаа эсвэл өөрчлөх шаардлагатай эсэх;</li> <li>• Ажиглалтууд нь Швейцарийн хамтын ажиллагааны үр дүнгүүдтэй уялдаатай байж болох үндэстэй эсэх.</li> </ul>
<b>Үзүүлэлтүүд</b>	Энэ шатны үр дүнг хянах 15 үзүүлэлтийг тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн дийлэнхийг ҮСГ эсвэл холбогдох яамдаас авна. Боломжтой бол хүйсээр ялгаж задалсан тоо баримт цуглуулж жендэрийн байдлыг харуулна. ҮСГ-ын үзүүлэлтүүдийг гол төлөв есдүгээр сарын стастистикийн бюллетингээс авах бөгөөд дөрөвдүгээр сард жилийн стастистикийн тайлан хэвлэгдсэний дараа тохируулга хийнэ.
<b>Давтамж</b>	ҮСГ-ын статистик тоо баримтыг есдүгээр сард авч, дөрөвдүгээр сард тохируулга хийнэ.

Швейцарийн хамтын ажиллагааны түвшний хяналт шинжилгээ нь энэхүү шинэ стратегийн хэрэгжилтийн явцыг хэмжих хамгийн чухал хэрэгсэл юм. Бүх шинэ төслийг тухайн үндсэн чиглэлийн үр дүнгийн хүрээнд нэгтгэж, Швейцарийн хамтын ажиллагааны стратегийн чиг баримжаанд нийцүүлнэ. Үндсэн чиглэл бүрийн үр дүнгийн нарийвчилсан хүрээг боловсруулсан (Хавсралт 2).

Швейцарийн хамтын ажиллагааны түвшний үр дүнгүүд	
<b>Үр дүнгүүд</b>	Швейцарийн санхүүжилттэй төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн хоорондын харилцан уялдааг харгалзсан долоон үр дүнг тодорхойлсон. Үр дүнд хяналт тавихдаа дараах зүйлсийг нягтална. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалт зорилтуудтайгаа уялдаатай хөгжиж байгаа эсэх;</li> <li>• Менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтаас улсын түвшний үр дүнд оруулах хувь нэмэр хүчин төгөлдөр эсвэл өөрчлөх шаардлагатай эсэх;</li> <li>• Эдгээр үр дүнд улсын түвшний үр дүнгүүдтэй шууд уялдаатайгаар хяналт шинжилгээ хийж байгаа эсэх</li> </ul>
<b>Үзүүлэлтүүд</b>	Энэ шатны үр дүнг хянах 15 үзүүлэлтийг тодорхойлсон. Эдгээрийн зарим нь хэд хэдэн төслийн үр дүнг нэгтгэсэн ерөнхий үзүүлэлт, зарим нь тодорхой хөтөлбөрийн онцлогыг тусгасан байна. Суурь үзүүлэлтийг 2012 оныхоор тогтоосон. Хөтөлбөрийн дараагийн үе шатанд илүү тохиромжтой мэдээлэл бий болвол тухайн шатны үзүүлэлтэд өөрчлөлт оруулж болно.
<b>Давтамж</b>	Төслөөс гаргасан тоо баримт: жилд нэг удаа Жилийн судалгаа: жилд нэг удаа



Швейцарийн хамтын ажиллагааны түвшний тоо баримтыг дараах хоёр эх сурвалжаас цуглуулна:

- Төслөөс гаргасан тоо баримт: холбогдох бүх төсөл зохих үзүүлэлтийн дагуу тоо баримтыг цуглуулж бэлтгэнэ (Хавсралт 4-ийг үзнэ үү).
- Жилийн судалгаа: ШХА-аас төслийн үр шимийг хүртэгч хамгийн том хоёр бүлэг болох малчид, тариаланчдын дунд жил бүр судалгаа явуулна. Уг судалгаа нь ШХА-ийн менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтын үзүүлэлтүүдэд зориулсан тоо баримтыг цуглуулж авах зорилготой.

Доорх бүдүүвчид улсын болон Швейцарийн хамтын ажиллагааны түвшний үзүүлэлтүүдийн эх сурвалж, цуглуулах хугацаа, үе шатыг харуулж байна.

## **В. Цуглуулсан мэдээллээрээ бид юу хийх вэ?**

Цуглуулж дүн шинжилгээ хийсэн мэдээллийг Жилийн тайланд тусгаж, жил бүрийн 10 дугаар сард ШХА-ийн Удирдах газарт тайлагнана. Энэхүү үйл явцаас гарах гол бүтээгдэхүүн бол тайланд оруулах үр дүнгийн тодорхойлолтууд (үндсэн чиглэл бүрээр гаргасан) байна. Уг тодорхойлолтууд нь үр дүнгийн ерөнхий үнэлгээнд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд дараах зүйлсийг үнэлэх зорилготой. Үүнд:

- Улсын түвшний үр дүнд хүрэх явцад тухайн улсад гарсан ахиц дэвшил, ололт амжилт, алдаа дутагдал.
- Тухайн улсын ололт амжилтад Швейцарийн менежментийн бүтэц, зохион байгуулалт, хуваарилалтын оруулсан хувь нэмрийн хамрах хүрээ.

Дүн шинжилгээ нь тухайн улсын хөтөлбөр, түүний дотор жендэрийн тэгш байдалд гарсан ололт амжилт, ахиц дэвшлийг онцолно. Түүнчлэн эдгээр үр дүнд хүрэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бодлогын яриа хэлэлцээ, зээл тусламжийн уялдаа зохицуулалтыг тусгана.

Улсын түвшний үзүүлэлтүүд

ҮСГ-ын үзүүлэлтүүд					ҮХААЯ	3	6	ХЯ	11
1	2	4	5	7	Есдүгээр сар	ДӨЧТ	12	ДЗҮ	14
8	9	10	13	Цахим худалдан авалт		15			
ХХӨХС									

Швейцарийн хамтын ажиллагааны түвшний үзүүлэлтүүд

Жил бүрийн судалгаа			Төслийн тоо баримт				
1	2	3	Есдүгээр сар	5	7	9	13
4	6	8		10	11	12	14
							15

1 Үзүүлэлт #    ■ ХАА болон ХАБ-ын салбар    ■ МБС    ■ Засаглал



**Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарийн  
хамтын ажиллагааны стратеги**

2013-2016

Швейцарийн хөгжлийн агентлаг

Скай Плаза Бизнес төв  
Олимпийн гудамж 12, 1-р хороо,  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот

Ш/х 37, Улаанбаатар 210648  
Монгол Улс

Утас: +976 11 331422

Факс: +976 11 331420

Э-шуудан: [ulaanbaatar@sdc.net](mailto:ulaanbaatar@sdc.net)

Веб: [www.sdc.mn](http://www.sdc.mn); [www.swissconsulate.mn](http://www.swissconsulate.mn)

Эх бэлтгэл, хэвлэлийг Гамма агентлаг